



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

**ШҮҮХИЙН БАЙР, ШҮҮГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД
ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ
СУДАЛГАА: ГАДААД УЛСЫН САЙН ТУРШЛАГА**



2019 оны 6 дугаар сар



Агуулга

УДИРТГАЛ	2
ШҮҮХИЙН БАРИЛГЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЙН ТУРШЛАГА (АНУ-ЫН ШҮҮХҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ)	4
НЭГ: ҮНДСЭН ЗҮЙЛ	4
А-1: Аюулгүй байдлын хороо	4
А-2: Бодлого ба дүрэм журам	5
А-3: Аюул ба ослыг мэдээлэх	8
А-4: Аюулгүй байдлын сургалт	9
ХОЁР: АНХААРУУШТАЙ	12
2-1: Хяналтын төв	12
2-2: Шүүгдэгч	13
2-3: Шүүхийн танхим	13
2-4: Шүүгчийн өрөө	16
2-5: Шүүхийн байранд нэвтрэх боломжтой хүмүүс	17
2-6: Нийтийн үйлчилгээний хэсэг, оффис	21
2-7: Шүүгчийн машины зогсоол	22
2-8: Эргэн тойрон дахь асуудлууд	23
ГУРАВ: ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГТЭЙ ЗҮЙЛС	25
3-1: Шүүхийн байранд ажлын цагийн дараа нэвтрэх	25
3-2: Онцгой байдлын тоног төхөөрөмж	25
3-3: Халдлага илрүүлэх систем	26
3-4: Ажлын цагаар дотогш нэвтрэх (эргэлтийн бүс)	27
3-5: Нийтийн хүлээлгийн танхим, коридор, шат, цахилгаан шат	28
3-6: Шүүхийн төлөөлөгч нарын аюулгүй байдал ба эргэлт	29
3-7: Бэлэн мөнгөтэй харьцах	29
3-8: Захидал болон илгээмж шалгах	30
ХАВСРАЛТ	34
Шүүхийн барилгын аюулгүй байдлын шилдэг практик (АНУ, Охайо муж)	34
Шүүхийн байгууламжийн аюулгүй байдлыг шалгах хуудас (АНУ, Аризона муж)	36



УДИРТГАЛ¹

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд зааснаар шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байна. Мөн шүүх хуралдааныг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нээлттэй явуулна.² Энэ нь иргэд шүүхэд чөлөөтэй нэвтрэх нөхцөл болох төдийгүй шүүн таслах үйл ажиллагаа хэвийн явагдахад бэрхшээл учруулах нэг хүчин зүйл болдог байна.

Олон улсын хэмжээнд 2001.09.11-ний өдрийн террорист халдлагын дараагаар шүүх, шүүгчийн аюулгүй байдлын асуудлыг онцгойлон анхаарах болсон. Үүнтэй холбоотойгоор шинжээчид судалгааны үр дүнд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой үндсэн 10 хүчин зүйлсийг тодорхойлсон байдаг.³ Үүнд дараах элемент хамаарна:

1. Үйл ажиллагааны аюулгүй байдал;
2. Барилга, байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөлт;
3. Онц байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээ;
4. Гамшгийн үед нөхөн сэргээх арга хэмжээ;
5. **Аюул, эрсдэлийн үнэлгээ;**
6. Осол, аюулыг тайлагнах;
7. Санхүүжилт;
8. Аюулгүй байдлын тоног төхөөрөмжийг бэлтгэх, түүний зардлыг шийдвэрлэх;
9. Хүний нөөц, хамтын ажиллагаа;
10. Шүүхийн байрны шинэ зураг төсөл.

Энэ судалгааны ажлын хүрээнд дээрх 10 хүчин зүйлсийн 5 дугаарт байх **“Шүүгчийн байр, шүүгчийн аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ”**-ий аргачлалын талаарх гадаад эх сурвалжийн лавлагааг танилцуулж байна.

Орчин үед шүүх засаглалыг хэрэгжүүлэх, удирдан явуулах, олон нийтийн итгэлийг дааж явах нь маш эмзэг асуудал болоод байна. Шүүхэд өдөр бүр эрх нь зөрчигдсөн болон түүний хариуцагчаар татагдсан олон иргэд үйлчлүүлдэг. Эдгээр эсрэг тэсрэг ашиг сонирхлуудыг зохицуулан гэм буруутай хүмүүсийг шийтгэж, тэгш эрх, шударга ёсыг хэрэгжүүлэх эрх бүхий институт нь шүүх билээ.

Шүүхийн аюулгүй байдал бол нэг удаагийн зорилго, хүрэх цэг биш, харин байнгын анхаарал тавих зайлшгүй шаардлагатай тасралтгүй процесс байх ёстой бөгөөд нийт хууль сахиулах байгууллагын хүчин чармайлтын үндсэн дээр тогтдог. Шүүхийн ажилтан бүр “аюулгүй байдал”-ын салшгүй нэг хэсэг. Шүүхийн захиргаанаас хэрэгжүүлж буй аюулгүй байдлын хүчин чармайлтыг шүүгчид идэвхтэй дэмждэг, оролцдог байх хэрэгтэй. Шүүгчид

¹ Энэхүү дэлгэрэнгүй судалгааг Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач-багш Ч.Содхүү гүйцэтгэсэн болно.

² Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 8 дугаар зүйл. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2012 он, №11

³ National Center for State Courts. CCJ/COSCA Court Security Handbook: Ten Essential Elements for Court Security and Emergency Preparedness. September 2012
<http://ncsc.contentdm.oclc.org/cdm/singleitem/collection/facilities/id/165/rec/12>



өөрсдөө аюулгүй байдалдаа онцгой анхаарч байвал шүүхийн ажилтнуудад үлгэр дуурайлал үзүүлэх болно.

Шүүх байранд аюулгүй байдлыг хянахад учирч болох эрсдэлүүд нь нэлээд өндөр бөгөөд олон янз байдалтай, тэдгээр нь хэзээ ч бүрэн үгүйсгэгддэггүй тул байнгын урьдчилан сэргийлэх болон хяналтад байх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Доорх сайн туршлагаудыг судлан өөрийн улсын онцлог нөхцөлд тохируулан нутагшуулан хэрэгжүүлбэл шүүхийн аюулгүй байдалд ихээхэн хувь нэмэртэй байх болно.

Энэ лавлагааны хүрээнд шүүхийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 1789 оноос хойш үйл ажиллагаа явуулж буй буюу хамгийн олон жилийн түүхтэй байгууллага болох АНУ-ын Маршалын алба (U.S. Marshals service⁴)-ын туршлага, үйл ажиллагааг доорх 3 сэдвийн хүрээнд орчуулан бэлтгэсэн материалыг хүргүүлж байна.

- ***АНУ-ын шүүхүүдийн үндэсний төвийн Шүүхийн барилгын аюулгүй байдлын шилдэг практик (NCSC-АНУ-ын шүүхүүдийн үндэсний төв)***

“Шүүхийн аюулгүй байдал”-ыг аюулгүй байдлын хороо, бодлого ба дүрэм журам, аюул ба ослыг мэдээлэх, аюулгүй байдлын сургалт гэсэн үндсэн 4 зүйлд авч үздэг ба тус бүр нь нарийн шат дамжлагатай, бие биенээсээ харилцан хамаарал бүхий үйл ажиллагаа байна.

- ***Шүүхийн байгууламжийн стандартууд (АНУ, Охайо муж улсын шүүх)***

Шүүхийн барилгын байршил, танхим, өрөө тасалгаа, номын сан, хэргийн оролцогчдын өрөө, иргэд олон нийтэд үйлчлэх өрөө, ажилтнуудын өрөө, орчин нөхцөл зэргийн аюулгүй байдал, харуул хамгаалалтын стандартын талаар

- ***Шүүхийн аюулгүй байдлын талаарх үнэлгээг тооцох шалгах хуудас (АНУ, Аризона муж улсын шүүх)***

Энэхүү шалгах хуудсаар шүүгч, ажилтнууд болон шүүхийн байгууламж дахь олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаар 23 төрөл бүхий 200 гаруй асуулттай асуултад дүгнэлт өгч үнэлгээг хийдэг байна. Энэ үнэлгээний үндсэн дээр цаашид шаардлагатай үйл ажиллагааны дүгнэлт гаргаж, шүүхийн аюулгүй байдлын стандартын дагуу хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулдаг байна.

⁴ U.S. Marshals Service website www.justice.gov/marshals/



ШҮҮХИЙН БАРИЛГЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЙН ТУРШЛАГА (АНУ-ЫН ШҮҮХҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ)

НЭГ: ҮНДСЭН ЗҮЙЛ

Энэ ангилалд багтах дөрвөн сэдэв нь Шүүхийн барилгын аюулгүй байдлын шилдэг практиктай холбоотой бүхий л сэдвүүдийн чухал суурь болдог:

- **А-1: Аюулгүй байдлын хороо.** Шүүхийн барилгын аюулгүй байдлын хороо нь шүүхийн байрны аюулгүй байдалтай холбоотой асуудлыг шийдэх, хяналт тавих эрх мэдэлтэй байдаг ба шүүх болон шүүхээр үйлчлүүлэгчдийн үйл ажиллагаанд тулгарч буй аюулгүй байдлын олон асуудлуудыг тодорхойлж, зөвөөр үнэлэн, шийдвэрлэдэг.
- **А-2: Бодлого ба дүрэм журам.** Шүүхийн барилга байгууламжийг аюулгүй байлгах баталгааг хангаж, тууштай хэрэгжүүлэхийн тулд аюулгүй байдлын үйл ажиллагааны нэгдсэн, цогц бодлого, процедурыг боловсруулах нь байнгын тогтвортой үйл явц юм.
- **А-3: Аюул ба ослыг мэдээлэх.** Аюул, ослыг мэдээлэх нь шүүгч, шүүхийн ажилтнууд болон шүүхээр үйлчлүүлж буй олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Болзошгүй сөрөг үйл явдалд шуурхай хариу арга хэмжээ авах, аюулгүй байдлын шилдэг туршлагыг бэхжүүлэх хүрээнд аюул, ослыг мэдээлэх тогтолцоог бий болгох хэрэгтэй.
- **А-4: Аюулгүй байдлын сургалт.** Шүүхийн барилгад ажиллаж байгаа хүн бүр аюулгүй байдлын "нүд, чих" нь болж эрсдэл, аюул заналыг байнга анхааран, ажлын байрныхаа аюулгүй байдлыг материаллаг байдлаар хангах боломжтой. Энэ нүд, чих болсон үйл ажиллагааг үр дүнтэй ашиглах хамгийн сайн арга бол шүүгчид болон шүүхийн ажилтнуудад аюулгүй байдлын бодлого, журмыг маш сайн сурталчлан бэлтгэх хэрэгтэй.

А-1: Аюулгүй байдлын хороо

Нэгдүгээр үе шат

1. Шүүхийн байранд шүүхийн аюулгүй байдлын хороо байгуулж, шүүгчээр удирдуулах (ихэвчлэн давамгайлсан байх), гишүүнчлэлд нь дор хаяж үндсэн аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэгч байх, мужийн болон бусад санхүүгийн эх үүсвэрийн төлөөлөгчтэй байх.
2. Шүүхийн аюулгүй байдлын хороо нь "хэн юу хийж байна, хэзээ, ямар нөөц шаардлагатайг шийдэх" үйл ажиллагааны төлөвлөлт дээр хуралдаанаа явуулна. Уг хороо нь энэхүү тайланд тусгагдсан зөвлөмжийг хэлэлцэж хэрэгжүүлэхийн тулд сар бүр уулзана. Дараа нь улирал тутамд уулзаж, бусад аюулгүй байдлын асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэнэ.
3. Шүүгч буюу шүүхийн захиргаа шүүхийн аюулгүй байдлын ажилтнууд болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудтай тогтмол эсвэл ямар нэг сөрөг үйл явдал гарсны дараа уулзаж, аюулгүй байдлын асуудлууд, шүүхийн байрны аюулгүй байдлыг сайжруулах талаар хэлэлцэх ёстой.

Хоёрдугаар үе шат



1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

4. Шүүхийн байранд аюулгүй байдлыг хангах сонирхолтой бүх оролцогч талуудыг төлөөлсөн хамгаалалтын хорооны гишүүдийг нэмнэ. Оролцогч талууд гэдэг нь мужийн байгууламжийн удирдлага, дүүргийн прокурор, улсын өмгөөлөгчид, олон нийтийн хамгаалагч, улсын буюу орон нутгийн өмгөөлөгчдийн давхарга, батлан даалтын хэлтэс болон бусад шүүхийн бус түрээслэгч зэрэг багтана. Хорооны хэмжээний хувьд сонирхлын бүлгүүдэд хүртээмжтэй, хороог зохицуулах боломжтой хэмжээгээр байлгах шаардлагатай. (Тус хороонд төлөөлөлгүй оролцогчид доорх 6-р алхмын үүрэг даалгаврыг томилж болно.)

Гуравдугаар үе шат

1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

5. Шүүхийн байранд байгаа аюулгүй байдлын талаарх өөрийн үнэлгээг хийх. Эдгээр үнэлгээг хийхэд шаардагдах шалгах хуудас нь Үндэсний Шерифийн Холбоо гэх мэт янз бүрийн эх сурвалжаас авах боломжтой.

Шилдэг туршлага

1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

6. Нэмэлт судалгаа, мэдээлэл цуглуулах чадавхтай хороог үүсгэх. Жишээлбэл, "Осол зөрчлийг мэдээлэх ба хууль бусаар хил давуулах наймааны" ажлын хэсэг нь аюулгүй байдлын хорооны гишүүнээр ахлуулж, ослыг мэдээлэх, контрабанд шинжилгээний тогтолцоог бий болгох үүрэгтэй ба энэ нь зөвхөн өгөгдлийг цуглуулдаг биш, мөн идэвхтэй дүн шинжилгээ хийж, авсан арга хэмжээний тухай мэдээлэх, хороонд өөрчлөлт оруулах зөвлөмжийг танилцуулдаг. Бусад ажлын хэсгийн нэмэлт гишүүд дараах зүйл багтаж болно:
 - Шүүхийн байранд ажиллаж байгаа шүүхийн ажилтнууд, IT-н ажилтнууд зэрэг
 - Орон нутгийн болон төрийн захиргааны албан хаагчид
 - Орон нутгийн болон муж улсын хуулийн мэргэжилтэн
7. Шүүхийн байгууламжийн зураг төсөл, барилга байгууламж, шинэчлэлийн төслүүдийн хорооны хүрээнд аюулгүй байдалд суурилсан төлөвлөлтийн хариуцлага нэмнэ.
8. Шүүхийн гаднах болон дотор хэсгийн аюулгүй байдлын арга хэмжээнд аудит хийх бие даасан мэргэжлийн байгууллагатай үе үе хамтран ажиллах.

А-2: Бодлого ба дүрэм журам

Нэгдүгээр үе шат

1. Шүүхийн аюулгүй байдлын хорооны ивээл дор (СЭДЭВ А-1-ийг үзнэ үү) шүүх, муж (мөн санхүүжилтийн бусад байгууллага), хууль сахиулах байгууллагын удирдлагууд шүүхийн барилгын үр дүнтэй, цогц аюулгүй байдлын бодлого, журмыг боловсруулах, хэрэгжүүлэхэд үүрэг хүлээх, үүний хэрэгцээ, шаардлагыг ойлгох ёстой. Ялангуяа шүүгчид шүүхийн аюулгүй байдлын тэргүүн эгнээнд байдаг гэдгийг анхаарах ёстой. Аюулгүй байдлын бодлого, журмыг боловсруулах, хэрэгжүүлэхэд шүүхийн манлайлал чухал байдаг.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:



2. Шүүхийн аюулгүй байдлын хорооны удирдлага дор мөн холбогдох хууль сахиулах байгууллагатай хамтран ажлын хэсэг байгуулах. Үүнд шүүхийн барилгын аюулгүй байдлын материалын нэгдсэн болон цогц багцыг боловсруулахдаа бодлого, журам, үйл ажиллагааны гарын авлага, сургалтын гарын авлага, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, ослын тайлагнал, эрсдэлийн үнэлгээний хэрэгсэл, протокол зэрэг зүйлсийг оруулах. Энэхүү цогц материалд хамрагдах асуудлуудыг жишээ болгон авч үзвэл:
- Шүүхийн барилгаас хориглосон зэвсэг, хууль бус зүйл/үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолт зэрэг үйл ажиллагаа болон протоколыг шалгах. Үүнд мөн эдгээр тохиолдлуудыг албадан хураах, баривчлах, устгах үйл явц зэрэг орно.
 - Дараах "Сөрөг үйл явдлууд"-ын удирдах:
 - Тэсрэх бөмбөгний аюул
 - Сэжигтэй илгээмж
 - Гал
 - Эмнэлгийн яаралтай тусламж
 - Шүүхийн танхим болон бусад шүүхийн байран дахь хүчирхийлэл
 - Шүүгдэгч оргох
 - Идэвхтэй галт зэвсэгтнүүд
 - Хүчтэй цаг агаар/эрчим хүчний тасалдал
 - Олон хүний анхаарал татах шүүх хурлыг удирдах
 - Зургийн аппарат/гар утсыг шүүхийн танхимд ашиглахыг хориглох, зэвсэг болгон ашиглаж болох бусад зүйлсийг хориглох.
 - Шүүхийн аюулгүй байдлын ажилтан (ШАБА-ууд) болон шүүхийн барилгын аюулгүй байдлын ажилтнуудын үүргийг тодорхойлох.
 - Шүүхийн барилгад зэвсэг авчирч болох эрх бүхий этгээдийг тодорхойлох.
 - Онцгой байдлын удирдлагын гарын авлага боловсруулах, оруулах, жишээлбэл, үүнд:
 - Шүүгчдийн өрөө, шүүхийн танхим болон бусад шүүхийн барилгын бүх хэсэгт хорих, нүүлгэн шилжүүлэх журам.
 - Онцгой байдлын зааварчилгааг зохих ёсоор авахын тулд давхар болгон дээр хариуцагчийг байрлуулах.
 - Түргэн тусламж дуудах үед давхрын хариуцагч, давхар болгоныг шалгаж, эмнэлгийн яаралтай (ж.нь, зүрх уушгины сэхээн амьдруулах (CPR) болон автомат гаднах дефибриллятор (AED) ашиглан) тусламжийг үзүүлнэ.
 - Онцгой байдал, сөрөг үйл явдлын үед ажилчдыг зориулалтын аюулгүй газарт цуглуулах, тэнд нь байлгах.
 - Онцгой байдал, сөрөг үйл явдлын үеэр командлалын төвд аюулгүй газар байгуулах.
 - Шүүгчид, ажилтнуудад харилцааны анхааруулах код зэрэг зүйлийг ашиглан мэдэгдэх аргуудыг боловсруулах (доороос үзнэ үү).
 - Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа шүүхийн бүх ажилчдад танилцуулсан байх.



- Тусгаарлагдмал хэсгийн шүүгчдэд зориулж аюулгүй байдлын тодорхой бодлого, журмыг тодорхойлох.

Гуравдугаар үе шат

1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

3. Бүх оролцогч талуудын ажилчдын холбоог бий болгох аюулгүй байдлын материалыг дахин нягтлах, шинэчлэх боломжийг дараах байдлаар олгодог:
 - Ажлын хэсэг болон оролцогч талуудын хоорондын харилцаа холбоог тогтоох.
 - Төрөл бүрийн хэлбэрээр оролцогч талуудад тогтмол танилцуулга өгөх.
 - Оролцогч талуудаас албан ёсны санал хүсэлтийг олж авах.
 - Оролцогч талуудын санал хүсэлтийг үндэслэн шаардлагатай шүүхийн аюулгүй байдлын материалыг хянан засварлах.
4. Албан ёсоор шүүхийн барилгын аюулгүй байдлын материал авах. Аюулгүй байдлын гол асуудлаар шүүхийн шийдвэрийг гаргах. Амжилттай байхын тулд аюулгүй байдлын баримт бичиг нь шүүгчийн дэмжлэгийг шаарддаг. Шүүхийн шийдвэр нь аюулгүй байдлын бодлогод хууль ёсны байх, хууль сахиулах боломжийг олгодог. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд шаардагдах гол асуудлуудын жишээнээс үзэхэд ажилчид, мөн орж ирж буй бүх хүнийг шалгах үзлэг хийх шаардлагатай.
5. Шүүхийн барилгын аюулгүй байдлын материалыг нийтлэх. Материалын талаарх дэлгэрэнгүй мэдээлэлд зайлшгүй мэдэж байх шаардлагатай зүйлс байна.

Дөрөвдүгээр үе шат

1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

6. Шүүхийн барилгын аюулгүй байдлын материалыг дараах байдлаар хэрэглэн дүгнэдэг:
 - Бодлого, журмуудын хэрэгжилтийг шалгахын тулд бэлтгэл дасгал сургуулилт хийх.
 - Бэлтгэл дасгалын үр дүнг үнэлэх.
 - Бодит сөрөг үйл явдал, тохиолдол дээр тулгуурлан үр дагаврын үр дүнг үнэлэх.
 - Шүүхийн барилгын аюулгүй байдлын материалыг бэлтгэл дасгалын болон бодит ослын үр дүнгийн үнэлгээнд тулгуурлан баталгаажуулна.
7. Анхны тусламж үзүүлэгч болон SWAT багийнхныг шүүхийн байранд оруулж, Шүүхийн Аюулгүй Байдлын Ажилтан (цаашид ШАБА гэх)-аар хамгаалуулж анхны тусламж үзүүлэгчдийг байгууламжтай танилцуулж, Тусгай Зэвсэгт Тактикийн Баг (SWAT)-ийнхныг шүүхийн байрыг үе үе сургалтад оролцуулах.

Шилдэг туршлага

1, 2, 3, 4-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

8. Бодлого, журмыг хоёр жил тутамд болон томоохон осол, үйл явдлын дараах байгууламжийг шинэчлэх, хянах.
9. 2, 3, 4 дүгээр үе шатуудыг үйл ажиллагааны үр ашгийн талаар дүн шинжилгээ хийнэ.

Шүүхийн барилга дахь харилцааны анхааруулах код



Үндэсний Кибер Аюулгүй Байдлын Төв (УКАБТ) болон яаралтай тусламжийн мэргэжилтнүүд нь онцгой байдлын үеэр харилцаа холбоо тодорхой, ойлгомжтой, энгийн байх ёстой гэж зөвлөдөг. Өнөө үед муж ба орон нутгийн шүүхүүд яаралтай тусламжийн үед юу хийх ёстой талаар шүүхийн барилгын ажилчиддаа зөвлөгөө өгөхийн тулд олон төрлийн анхааруулах систем, хэлийг ашигладаг.

Колорадогийн Колумбийн ахлах сургуульд болсон буудлагын үр дүнд өнгөт кодыг анх Канзасын Оатеш хотын ахлах сургуулийн захиргаа боловсруулсан байна. Тэр цагаас хойш өнгөт кодыг даган үг хэллэгийг сургуулиуд, коллеж, их дээд сургуулиуд, эмнэлэг, муж улсын шүүхүүдэд яаралтай үед ашиглах болсон байна. Онцгой байдлын үеэр шүүхийн байрыг орхин явах эсвэл гарах эсэх нь ихэвчлэн амь нас, үхэл хоёрын хоорондын ялгаа юм.

Тодорхой харилцаа холбоо, ойлгомжтой, энгийн заавар нь барилгын ямар ч нөхцөлд амин чухал юм. Одоогийн нүүлгэн шилжүүлэлтийн журмыг сайжруулахын тулд шүүх өнгөт код, аман тушаал, дасгал сургуулилтыг ашигладаг. Шүүхийн бүх барилга байгууламжид адилхан өнгөт кодыг ашиглан аман зааварчилгаа авах нь шүүхийн ажилтнууд бусад түрээслэгч, иргэний төлөөлөгчид, олон нийт яаралтай үед зөв хариу үйлдэл хийхэд тусалдаг.

Зөвлөж буй өнгөт код

- **Код Улаан** – Аюул заналхийлж байна
 - Идэвхтэй галт зэвсэгтэй этгээд шүүхийн байранд байна эсвэл хүн барьцаалагдсан.
 - Урьдчилан тодорхойлсон яаралтай тусламжийн төлөвлөгөөний дагуу хамгаалалт бүхий байрлал эсвэл аюулгүй орчинд очих (жишээ нь, гүйх, нуух, тулалдах).
- **Код Улбар шар** – Онцгой байдал: Барилгаас нүүлгэн шилжүүлэх
 - Давхрын хариуцагчийн зааврыг сонсох.
 - Шүүхийн байрнаас хол өөрийн оноосон байршилд очих.
- **Код Шар** – Онцгой байдал: Аврах багийнхан хариу үзүүлж байна
 - Онцгой байдлын баг хариу арга хэмжээ авч байна эсвэл шүүхийн барилгад нэвтэрсэн.
 - Албаны хүмүүсээс нэмэлт зааварчилгааг хүлээх.
- **Код Цэнхэр** – Нөхцөл байдлыг мэдсэн байх
 - Анхааруулга: Сэрэмжтэй байх, аюулыг даван туулахад бэлэн байдалтай байна.
 - Барилгад аюултай нөхцөл байдал үүсэж байна.
- **Код Ногоон** – Захиргааны / Мэдээллийн
 - Хэвийн үйл ажиллагаанд буцаж очих.
 - Бүх зүйл хэвийн болсон.

А-3: Аюул ба ослыг мэдээлэх

Тодорхойлолт

АЮУЛ – гэдэг нь бусад этгээдэд (шүүхийн ажилтан эсвэл шүүх хуралд оролцогчид) өвчин зовлон, гэмтэл, хохирол, дайсагнасан үйлдэл үзүүлэх, эсвэл шүүхийн байгууллагад



(шүүхийн байр) хохирол учруулж, одоо болон ирээдүйд цээрлэсэн үйлдэл хийсэн эсвэл хийхийг завдсан оролдлогыг хэлнэ. Аюул занал нь заналхийлсэн үг, сануулга, эсвэл тулган шаардсан зэрэг заналхийлэлтэй ижил утгатай үг хэллэг юм. Аюул занал нь хохирол эсвэл аюул учруулах магадлалтай хүн, эд зүйл байж болно.

ОСОЛ – гэдэг нь хувийн гэмтэл, эд хөрөнгийн хохирол учруулсан, шүүхийн шийдвэрийг тасалдуулах шалтгаан, эсвэл заналхийлэх үйлдэл юм уу мэдээллийг хэлнэ. Шүүхийн ажиллагаанд шүүхийн танхим болон шүүхийн байгууламжийн гадна доторх үйл ажиллагаа орно. Тайлбар: Энэ тодорхойлолт нь үйлдэл нь бие махбодын хувьд (хувийн гэмтэл, эд хөрөнгийн хохирол) илэрч болзошгүй, эсвэл үүнтэй адил аюул заналхийлж болох магадлал дээр төвлөрдөг.

Нэгдүгээр үе шат

1. Аливаа аюул заналхийлэл, осол зөрчлийг шаардсан бодлогыг хууль сахиулах байгууллагад болон шүүхийн захиргааны байгууллагад аль болох түргэн мэдэгдэх ёстой гэхдээ аюул заналхийлэл, осол гарсан өдрийн ажлын цаг дуусахаас өмнө байна. Аюул, осол хэр аюултай байна төдий чинээ хурдан мэдээлэх ёстой.
2. Шүүхийн байранд ШАБА-ууд, шүүгчид, ажилчдыг хэрхэн аюул, ослыг таньж мэдэх, мөн амаар болон бичгээр хэрхэн мэдээлэх талаар сургах.
3. Аюул, ослын тайлангийн маягтыг боловсруулж ашиглах, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад дор хаяж сар тутам электрон хэлбэрээр гаргаж, томилогдсон сурвалжлагчид өөрсдийн тайлан өгч, шаардлагатай зааварчилгаа/туслалцааг илүү хялбараар авч болно. Шүүхийн аюулгүй байдлын хороо бүх аюул, ослын тайлангуудын хуулбарыг авах ёстой.
4. Төрийн болон мужийн түвшинд сонирхогч талуудтай аюул занал, ослын мэдээллийг зохицуулах. Бүх чиглэлийн "эргэх холбооны эргүүлэг" -ийг бий болгох.

Шилдэг туршлага

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

5. Хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон шүүхийн аюулгүй байдлын хорооны дарга болон хорооны ослын тайлагналтын ажлын хэсэгтэй хийсэн тайлангийн сургамж дээр үндэслэн гарсан ослын тайланг байнга шинжиж, сайжруулж байна.
6. Ажилчдад, ялангуяа мэдээлсэн хүмүүст аваар ослын талаар ерөнхий мэдээлэл өгөх.
7. Аюул, осол зөрчлийн талаар мэдээлэх цахим систем бий болгох, нөөцийг түргэн шуурхай хянаж, байршуулах, олон тооны хувьцаа эзэмшигчид хянах, хариу өгөх боломжуудыг бий болгох. Мэдээллийн санг бүх холбогдох мэдээллээр хангана. Өгөгдлийн санг орон нутгийн болон мужийн түвшинд байлгах ёстой.

А-4: Аюулгүй байдлын сургалт

Нэгдүгээр үе шат

1. Сургалт бол бүх шүүхийн барилгын аюулгүй байдлын арга хэмжээг холбодог цавуу юм. Аюулгүй байдлын сургалт нь байнга, давтамжтай бас энгийн байх шаардлагатай. Сургалтгүй бол ажилтнууд болон ШАБА-ууд хэзээд бэлтгэлгүй байх болно. Бүх ажилтнууд болон ШАБА-уудад аюулгүй байдлын сургалт шаардлагатай байдаг. Сургалтыг заавал байх ёстой бөгөөд түгээмэл хийх нь нэн чухал. Үүнд



шүүгч нар ялангуяа оролцох ёстой. Шүүгч нь аюулгүй байдлын сургалтад идэвхтэй оролцоноор бусад ажилтнуудад эерэгээр үлгэрлэдэг.

2. Шинэ шүүгчид болон шүүхийн ажилтнууд аюулгүй байдлын анхны танилцуулгад оролцох ёстой бөгөөд үүнд галт зэвсэгтэй этгээд, хүн барьцаалах, яаралтай арга хэмжээ авах (жишээ нь: гал, цаг агаарын болон эмнэлгийн яаралтай үед), нүүлгэн шилжүүлэх замууд, онцгой байдлын өнгөний код, ажил болон гэртээ аюулгүй байдлын журмыг сахих гэсэн сэдвийг хэлэлцдэг.
3. Шүүгчид болон шүүхийн ажилтнууд гэртээ эсвэл шүүхийн байранд тулгарсан заналхийлэл, ослын талаар тодорхой мэдээллийг өгнө.
4. ШАБА шүүхийн үндсэн аюулгүй байдлын үүрэг хариуцлага сурсан байх ёстой. ШАБА шүүгчийн аюулгүй байдлын арга техник, шүүхийн болон ажилтнуудын хамгаалалт, аюулгүй байдлын хяналт шалгалтын үйл ажиллагаа, галт зэвсэг, аюул заналхийллийг бууруулах арга техник, аюулгүй байдал, зэвсгийн гэрчилгээ зэрэг хичээлийн анхны зааварчилгааг авах ёстой.
5. ШАБА нь онцгой байдлын үед хариу арга хэмжээ, анхны тусламж, хамгаалалтын тактик, гав, шүүх хурлын аюулгүй байдал, барьцаалагдсан хүн, галт зэвсэг, шүүхийн хамгаалалт зэрэг үндсэн сургалтад хамрагдах ёстой.
6. Тушаалын төвийн ажилчид нь чухал ослын команд болон түгшүүрийн харилцаа холбооны чиглэлийг сурсан байх ёстой.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

7. Ажлын байрны хүчирхийлэл, хувийн аюулгүй байдлын арга техник, шүүх танхимын аюулгүй байдал, хамгаалалт, дотор болон гадна байх үеийн шүүгч, ажилтнуудын хувийн аюулгүй байдлыг хангах тасралтгүй боловсролын хөтөлбөрийг бэхжүүлэх.
8. Бүх ШАБА-д жил бүр хамгийн багадаа 24 цагийн шүүхийн аюулгүй байдлын талаар сургалтад албадан хамруулна.
9. Анхны тусламж үзүүлэх ажилчид, ялангуяа SWAT багийг урьж, шүүхийн байртай танилцуулах. SWAT баг нь өөрийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд шүүхийн байрыг ашиглахад нь дэмжлэг үзүүлнэ.

Гуравдугаар үе шат

1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

10. Шүүгч болон шүүхийн ажилтнуудад зориулсан аюулгүй байдлын болон хамгаалалтын хөтөлбөрийг бий болгох. Үүнд, аюулгүй байдлын анхны товч мэдээлэлд тусгагдсан сэдвүүд, хүнд хэцүү хүмүүс, уур хилэн-менежмент, гэрийн аюулгүй байдлын арга техник, дотооддоо болон шүүхийн гаднах аюулгүй ажиллагааны практикууд, барьцаалах тохиолдлууд, шүүхийн байрнаас яаралтай нүүлгэн шилжүүлэлт зэрэг сэдвүүд багтаана.
11. Галт зэвсгийн талаар жил бүр танилцуулах, мэргэшүүлэх курсүүдээс гадна ШАБА-дад зориулан тогтмол давтан сургах сургалтыг зохион байгуулах ёстой. Үүнд, онцгой байдлын хариу арга хэмжээ, анхны тусламж, хамгаалалтын тактик, гав, шүүх хурлын аюулгүй байдал, барьцаалах тохиолдлууд, галт зэвсэгтэй этгээд, шүүхийн хамгаалалт гэх зэрэг сэдвүүд багтаана.

Шилдэг туршлага



- 1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
12. Шүүгч болон шүүхийн ажилтнуудад зориулсан аюулгүй байдлын боловсролын хөтөлбөрүүдийг бий болгох, үүнд олон нийтийн сонирхох шүүх хурал, гэрийн аюулгүй байдлын техник, гадуур зорчих үеийн аюулгүй байдлын зөвлөмж, сэжиг бүхий илгээмж, тэсрэх бөмбөг, бусад аюул заналхийлэл, мөн шүүхийн байрнаас яаралтай нүүлгэн шилжүүлэх зэрэг багтана.
 13. Барьцаалагдсан үед шүүгчид болон шүүхийн ажилтнууд өөрсдийгөө хамгаалах, заналхийллийг бууруулах, хувийн аюулгүй байдлын арга техникт сургах.
 14. ШАБА-дад шүүхийн дэвшилтэт сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хуваарилах. Үүнд аюул заналхийлэл, аюулгүй байдлын үнэлгээ, шүүхийн хамгаалалт, ослын хариу арга хэмжээ, аюултай хүмүүс, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал зэрэг орно.





ХОЁР: АНХААРУУШТАЙ

2-1: Хяналтын төв⁵

Нэгдүгээр үе шат

1. Шүүхийн төвийн, аюулгүй, стратегийн байршил бүхий хэсгийг байгуулан шүүхийн аюулгүй байдлын ажилтныг (ШАБА*) томилох. Хязгаарлагдмал нөөц бололцоотой жижиг байгууламжуудад, хяналтын төв нь ШАБА-ы ширээн дээр хяналтын дэлгэц байхад хангалттай байж болно. Тушаалын төвд томилогдсон ШАБА нь заавал галт зэвсэгтэй байх шаардлагагүй. Шүүхийн жижиг барилгуудын хувьд, хяналтын функц нь орох хэсэгтэй ойролцоо байж болно.
2. Хяналтын төв нь дохиоллыг байнга хянаж байна.
3. Телефон/радио холбоог ШАБА болон шүүхийн танхим, танхим гэх мэт шүүхийн барилгын эмзэг газартай холбох цэг болгож өгнө.

**Тайлбар: Энэхүү баримт бичигт дурдсан ШАБА нь шүүхийн барилгын аюулгүй байдлыг хангах мэргэшсэн, бие даасан бөгөөд энгийн зэвсэг, тухайлбал, цахилгаан буу, химийн шүршигч, эсвэл баривчлах зэвсэг (тухайлбал, гав, хөлний гав) хэрэглэх чадвартай хүн гэж тодорхойлно.*

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

4. Шүүхийн байрны аюулгүй хэсэгт хяналтын төвийг байгуулна. Хэрэв энэ боломжгүй бол хяналтын төвд орох хязгаарлалт хийж, хяналтын төвийн хаалга, цонх, бусад дайралтад өртөж болзошгүй бусад хэсгийг баллистик тэсвэртэй хамгаалалт хийнэ.
5. Аюулгүй байдлын хяналтын камер, аваарын дохиолол, галын дохиолол, сэрэмжлүүлэг, халдлага илрүүлэх систем, утас, радио холбоо, диспетчер зэрэг хяналтын самбар, хяналтын тоног төхөөрөмж сууриллуулна.

Шилдэг туршлага

1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

6. Хяналтын төвийн үйл ажиллагаанд удирдах, хяналт тавих үүрэгтэй нэмэлт хамгаалалтын ажилтнуудыг хангах. Шүүхийн байр олон нийтэд нээлттэй байгаа үед хяналтын төв байнга ажиллах ёстой.
7. Хяналтын төвийн ажилтнууд нь хямралын үед бие өөрсдөө оролцож болохгүй. Тэднийг хяналтын төвөөс нь холдуулж "тулалдуулбал" яаралтай нөхцөл байдлын талаарх мэдлэгийг ажилтнуудад түгээх чухал элемент алдагдахад хүргэнэ. Хяналтын төвөөс гаргасан нөхцөл байдлын талаарх мэдэгдэл дээр тулгуурлан тусламж үзүүлэгчид хамгийн оновчтой тактикийн шийдвэр гаргаж, ажилтнуудыг байлгах, эсвэл шилжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

⁵ Энэ баримт бичигт дурдсан хамгаалалтын хяналтын төв нь шүүхийн барилгын аюулгүй байдлын бүх үйл ажиллагааг хянаж, аюулгүй байдлын дэд бүтцийг хянаж байдаг биет байрлалыг хэлнэ. Аюулгүй байдлын "хяналтын төв" нь шүүгдэгчийг тээвэрлэн саатуулдаг "хяналтын өрөөнөөс" өөр чиг үүрэгтэй. Зарим шүүхийн байранд хяналтын төв ба хяналтын өрөөг нэгтгэсэн байдаг.



2-2: Шүүгдэгч

Нэгдүгээр үе шат

1. Шүүгдэгчийг бүх аюулгүй бус газруудаар дамжин, энгийн иргэдийг замаас холдуулан харгалзан явах наад зах нь нэг ШАБА томилох.
2. Шүүхийн танхимд яллагдагчтай байнга байх нэг ШАБА-г томилох.
3. Шүүхийн байранд шүүгдэгчийг чөлөөтэй явуулахгүйн тулд хамгийн бага хүнтэй үед нийтийн газраар дагуулан явуулах хуваарь гаргах хүчин чармайлт гаргана. Шүүгдэгчийг дагуулж явахаас өмнө олон нийтийг замын хажуу болон бусад хэсэг руу холдуулна.
4. Шүүгдэгчийг олон нийтийн замаар дагуулж явахдаа хөндлөнгийн хүмүүсийг танхимын хамгийн хойно хүртэл зөөн холдуулна. Шүүгдэгчийг нийтийн цахилгаан шатаар дагуулж явах үед лифтэнд бусад өөр хүнийг оруулахгүй.
5. Шүүгдэгчийг дагуулж явахдаа гар хөлийн гав ашиглан сайн хүлэх ёстой. (Тэднийг урд талд нь гавлах ёсгүй.)
6. Шүүгдэгчийг дагуулж явах үед олон нийт, гэр бүл, найз нөхөдтэйгөө ямар ч төрлийн, аман болон бие махбодын холбоотой байх ёсгүй.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

7. Шүүгдэгчийг тээвэрлэх болон саатуулах үүргийг хяналтын төв хариуцна. Хяналтын төв нь шүүгдэгчийн орших болон явах хэсгийг сайтар шалгана. Өмнөх хэсэгт дурдсанчлан, зарим барилгад энэ функцийг аюулгүй байдлын хяналтын төвд байршуулж, удирдаж болно.
8. Хоёр дахь ШАБА-г томилон шүүгдэгчийн явах замыг чөлөөлүүлнэ. Энэхүү офицер нь шүүгдэгчтэй хамгийн ойр байх бөгөөд цахилгаан буу, химийн шүршигч зэрэг энгийн зэвсгээр зэвсэглэсэн байна, нөгөө хойно явах офицер нь мөн л зэвсэглэсэн байна
9. Шүүхийн барилга доторх бүх саатуулах үүр ба хэсгүүдэд зохих ёсоор хамгаалагдсан, зохион байгуулалттай, харгалзагчтай байна.

Гуравдугаар үе шат

1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

10. Шүүгдэгчийн явах замд бүхэлд нь аюулгүй байдлын камер суурилуулна.
11. Шүүгдэгч барилгад ороход аюулгүй хамгаалагдсан порт бий болгох.

Шилдэг туршлага

1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

12. Яллагдагчийг тээврийн хэрэгслээс хамгаалагдсан портоор дамжуулж саатуулах үүр хүртэл зорчиход, шүүхийн танхим, шүүгч, ажилтан, олон нийтэд харагдуулахаас зайлсхийнэ.

2-3: Шүүхийн танхим

Нэгдүгээр үе шат



1. Хэрэв давхар болгонд нэг ба түүнээс дээш шүүхийн танхимтай бол тэрхүү давхарт доод тал нь нэг ШАБА-г томилон хурлаас хуралд шилжин оролцоно.
2. Шүүгдэгч шүүх хуралд оролцож буй тохиолдолд шүүхийн бүх үйл явцын туршид дор хаяж нэг ШАБА байна.
3. Шүүхийн танхимд аваарын дохиоллыг хүрч болохуйц газруудад байрлуулах:
 - Сандлын дээр эсвэл доор тодорхой тэмдэглэн байрлуулах
 - ШАБА-н станцад
 - Хүлээн авахын хэсэгт
4. Шүүгч болон ажилтнуудад аваарын дохиоллын функц, ашиглах протоколыг заах.
5. Аваарын дохиоллыг тогтмол шалгаж байх (дор хаяж сар болгон).
6. Шүүх ажиллагаа явагдахаас өмнө өглөө мөн бүх шүүх хуралдаан дууссаны дараа хяналт хийнэ. Тайлбар: Ямар ч үе шатанд олон нийтийн сонирхолд байгаа шүүх хуралд буу, тэсрэх бодис, бусад тэсэрч дэлбэрэх контрабанд илрүүлэх чадвартай бэлтгэгдсэн нохой ашиглана. Үүнээс гадна шүүх хурлын завсарлагаанаар эсвэл шүүх хурал болоогүй үед шүүхийн танхимыг цэвэрлэж, заавал түгжих ёстой. Хэрэв хувь хүмүүс завсарлагааны үед шүүх танхимд үлдэж болох бол ШАБА тухайн газарт мөн харгалзан үлдэх үүрэг хүлээх ёстой.
7. Шүүхийн танхим дотор зэвсэг болгон ашиглаж болох эд зүйлсийг (жишээ нь, хайч, үдэгч, металл усны сав, шил) аюулгүй газар байлган эсвэл зайлуулах ёстой. Эдгээр зүйлсийг полимер буюу цаасан бүтээгдэхүүнийг ашиглан орлуулж болно. Яллагдагч нь шантгар үзүүртэй хайч, уян хатан үзэг, жижиг үдэгч зэргийг ашиглаж болно. Хөдөлдөг тавилгыг (жишээ нь: хөдөлдөг эсвэл нугардаг сандал) аюулгүй газар байлган эсвэл зайлуулах ёстой.
8. Шүүхийн танхимд онцгой байдлын гэрэлтүүлэг/гал түймрийн тоног төхөөрөмжийг байнга суурилуулж, дараа нь байнга шалгаж байх.
9. Шүүхийн танхимыг ашиглаагүй үед бүх хаалгыг байнга түгжих. Шүүхийн бүх хаалгыг дотроос нь хялбархан цоожлох боломжтой байх ёстой.
10. Сандалд хамгийн ойрхон байрлах шүүхийн танхимын хаалганууд хаалттай байх ёстой боловч шүүх хурал явагдаж буй үед түгжиж болохгүй, энэ нь шүүгчид ноцтой асуудал үүсэхэд хурдан гарах боломж олгодог. Энэ нь ШАБА-ны шүүх танхимд байх үед шүүхийн танхимд зөвшөөрөлгүйгээр нэвтрэх оролдлого хийхээс урьдчилан сэргийлнэ гэж үздэг. Хэрэв ШАБА шүүх танхимд байхгүй байж болзошгүй гэж үзвэл карт уншигчтай автомат түгжигчтэй хаалга суурилуулсан байна. Карт уншигч суурилуулсан бол шүүгч картаа ашиглахад бэлэн байх хэрэгтэй.
11. Төрийн хууль тогтоомжийн дагуу зохистой, хүлээн зөвшөөрч болохуйц гав ашиглана. Шүүгдэгчийг шүүхийн үйл ажиллагааны үед эсвэл хуулийн дагуу хориглосноос бусад тохиолдолд, гар, хэлний гав, гэдэсний гинжээр номхотгох ёстой.
12. Шүүгч шүүхийн танхимд ороход зориулан хаалганы дуран суурилуулна.
13. Зэвсгийг ажиллуулах боломжгүй болгох. Сумыг нь битүүмжилсэн нотлох уутанд галт зэвсгээс тусад нь хадгалах.
14. Шүүхийн танхимд эмх замбараатай байлгах тушаал гаргах.



15. Олны нүдэнд байгаа шүүн таслах ажиллагаа болон бусад шаардлагатай арга хэмжээнд, танхимын урд эгнээний хэсгийг хоосон байлгах эсвэл яллагч болон яллагдагчийн найз нөхөд, гэр бүлийнхнийг тусгаарлан суулгах гэх мэтийн аюулгүй байдлын бусад арга хэмжээг бий болгох.
16. Гомдол гаргах, ял сонсгох үед яллагдагчийг суугаа байдалтай байлгах талаар журам боловсруулах. Суугаа байдалтай яллагдагчид хяналт тавихад илүү боломжтой ба, үймээн гаргах магадлал багатай байдаг.
17. Ширээ, тавцанг сандлаас зайтай байлгах.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

18. Шүүх хурал явагдаж буй үед ядаж нэг ШАБА танхимд байх ёстой. Хоёр дахь ШАБА нь шүүгдэгч шүүх хуралд оролцох үед байна. Шүүгдэгчийг харгалзах офицер галт зэвсгийн оронд цахилгаан буу, хий зэргээр зэвсэглэсэн байна. Энэ нь шүүгдэгч зөрчлийн үед галт зэвсгийг булаан авах боломжийг багасгадаг.
19. Аюулгүй байдлын камерыг эрүүгийн болон гэр бүлийн шүүхэд суулгаж болно. Үндсэн аюулгүй байдлын камер нь сандлын ард заал руу харсан байна.
20. Шүүхийн саатуулах үүрийг зохистойгоор барьж, шүүгдэгч аюулгүй, зугтаах боломжгүй байх ёстой.
21. Гурван сар тутамд шүүгч шүүх хурлын танхимд болсон үйл явдлуудын талаар ярилцах, шүүх хурлын өрөө аюулгүй байдалтай холбоотой журмыг хянах зорилгоор шүүхийн ажилтнуудтай уулзалт хийнэ. Аюулгүй байдлын аливаа чухал үйл явдлын дараа даруй мэдэгдэл хийх шаардлагатай.
22. Шүүхийн танхим болон ажлын хэсгийн сандалд суманд тэсвэртэй материал суурилуулна. UL стандарт 752 дагуу баллистик тэсвэртэй материалыг олон нийтэд харагдахуйц сандал, станцуудын босоо гадаргуугийн ард байрлуулсан байна. Суманд тэсвэртэй шилэн хавтан зардал хэмнэсэн материал ба тусгай нарийн хэлбэрээр зүсэн шүүхийн заалны арын хэсэгт суулгаж болно.

Гуравдугаар үе шат

1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

23. Хоёр дахь ШАБА-г ямар ч шүүх ажиллагаа явагдаж байх үед томилж болно. Шүүгдэгч байгаа эсэхээс үл хамааран, эхний ШАБА шүүгчид, нөгөө нь шүүхийн танхимд хуваарилагдаж болно. Хоёр дахь ШАБА нь шүүгч өөрөө хүсэлт гаргаагүй л бол энгийн иргэний шүүх ажиллагаанд байх шаардлагагүй.
24. Бусад шүүхийн танхимд нэг хяналтын камер суурилуулах. Камер нь сандлын ард заалруу харсан байна.

Шилдэг туршлага

1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

25. Олны нийтийн анхааралд байгаа нээлттэй шүүн таслах ажиллагаанд нэмэлт ШАБА-г томилж болно.
26. Шоронд зөвлөгөөн/шүүхэд татагдах болон бусад байцаалтад зориулж шүүхийн танхим байгуулах. Хэргийг шийдвэрлэхэд хуулиар зөвшөөрсөн хэмжээнд цахим



арга ашиглана. Хэргийг цахимаар шийдвэрлэх нь яллагдагчийг хуралруу нааш цааш авч ирэхэд тохиромжтой гэж тооцдог.

27. Бүх шүүхийн танхимд бэлтгэгдсэн нохой ашиглан нэгжлэг хийнэ.
28. Шүүхийн нарийн бичигч болон бусад ажилтнуудыг шүүх хуралдааны ажиллагааг дуусгавар болсны дараа ашиглах тусдаа ажлын байраар хангах (шүүхийн танхимд биш)
29. Бүх шүүхийн танхимд хоёр аюулгүй байдлын камер суурилуулна:
 - Өмнөх үе шатанд тайлбарласанчлан шүүхийн танхимд үйл ажиллагаанд хяналт тавихын тулд нэг камерыг ханан дээр суулгана.
 - Шүүхийн танхимын үйл ажиллагаанд хяналт тавихын тулд арын хэсэгт хоёр дахь камер суурилуулах ба үүнд шүүгчдийн хэсэг, сандал харагдаж байна.
30. Шүүхийн танхимд автомат электроник түгжээ суурилуулах.

2-4: Шүүгчийн өрөө

Нэгдүгээр үе шат

1. Шүүгчийн өрөөний аюулгүй байдал, хувийн аюулгүй байдлын талаар шүүгч болон шүүхийн ажилтнуудад сургалт явуулах.
2. Шүүгчийн ширээн болон хүлээн авахын хэсэгт аваарын дохиоллыг суурилуулах.
3. Аваарын дохиоллыг байнга шалгаж байх – дор хаяж сар бүр. Шүүгчид, шүүхийн ажилтнуудад яаралтай дохиоллыг хэрхэн яаж хэрэглэхийг сургах. Шүүгчид, шүүхийн ажилтнуудад аваарын дохиоллыг хэзээ хэрхэн яаж хэрэглэхийг сургах.
4. Шүүгчийн өрөө хамгаалалтгүй байвал шүүгчийг хамгаалан танхимд оруулна.
5. Шүүхийн үйл ажиллагааг гаднаас нь ажиглуулахгүй байхын тулд тасалгааны цонхны хучилтыг байнга хаалттай байлгана.
6. Өглөө орой болгон шүүгчийн өрөөнд байнга эргүүлэг хийнэ.
7. Өрөөний орох хаалгыг байнга түгжээтэй байлгах. Шүүгч байхгүй үед, ялангуяа шөнийн цагаар шүүгчийн өрөөний хаалгыг түгжээтэй байлгах.
8. Шүүгдэгчид хонгилоор явж байх үед шүүгчид өрөөнөөсөө гадагш гарахгүй байх урьдчилан мэдэгдэл өгнө.
9. Өрөөнд тавилга байрлуулахдаа аюулгүй байдлыг анхаарч байх. Жишээ нь, шүүгчийн гарах хаалгыг зочны сандал хаагаагүй байна. Түүнчлэн шүүгчийн сандлыг гаднаас шууд харагдахаас зайлсхийн аль болох боломжтой хэсэгт байрлуулах ёстой.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

10. Бүх шүүгчийн өрөөнд цонхны хаалт суурилуулах.
11. Өрөөг гаднаас нь харагдахгүй байлгахын тулд цонхны хучилтыг байнга хаалттай байлгана.
12. Өрөөнд орох гарахыг хянах видео харилцаа холбоо болон алсын удирдлагатай соронзон хаалганы систем бий болгох.
13. Өрөөнд онцгой байдлын сургуулилт хийх, төлөвлөх.
14. Шүүгчдийг шүүх танхим, өрөөг орхиж гарахад ШАБА-д даатгах.



Гуравдугаар үе шат

- 1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
15. Шүүгдэгчдэд зориулсан явах коридор байхгүй нөхцөлд, шүүгдэгчийг наад зах нь хоёр ШАБА коридороор газарчлан, замыг саадгүй болгоно. Шүүгдэгчийг хариуцсан офицер нь галт зэвсэгтэй байх ёсгүй хэдий ч, цахилгаан буу, химийн шүршигч зэрэг энгийн зэвсэгтэй байна; нөгөө офицер биедээ галт зэвсэг авч явах ёстой.
 16. Шүүгдэгч коридороор явах үед, шүүгч болон ажилчдад мэдэгдэх үүднээс шүүгчийн өрөө дагуу коридорт дуу, гэрэлтүүлгийн систем суурилуулах.
 17. Хүрч болмоор бүх цонхонд тэсрэх бөмбөгт тэсвэртэй материал (ж.нь, газрын түвшин, эхний давхарт) суурилуулна. Баллистик тэсвэртэй материал нь IV түвшингийн UL Стандарт 752-т нийцэх ёстой. Зэргэлдээ байгууламж, газар зүйн байршлын онцлогтой холбоотой зүйлээс хамааран доод давхрын эрсдэлийн үнэлгээгээр зөвтгөгдөн бусад тохиолдолд үүнийг дагахгүй байж болно. Энэ түвшинг аюулгүй байдлын тусгай үнэлгээнд тулгуурлан багасгаж болно.
 18. Цэвэрлэгээний багийг шөнийн цагаар биш, шүүхийн ажилтан байх үед үдээс хойш танхимыг цэвэрлэж байхыг хүсэх. Цэвэрлэгээний багийг шүүхэд хариуцлага хүлээх хэн нэгэн хариуцна.

Шилдэг туршлага

- 1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
19. Аюулгүй байдлын камерыг коридорт өрөөнд орох хаалгаруу харуулан суурилуулах.
 20. Боломжтой бол шүүхийн барилгын одоогийн бүтцэд тохируулж, шүүгчдийг өрөөнөөсөө шүүхийн танхим хүрэх аюулгүй замыг бий болгох. Боломжтой бол, хорих ангиуд дахь шүүгдэгчид шүүгчдийн өрөөний коридороор холхилдохгүй аюулгүй замыг бий болгох.
 21. Баллистик тэсвэртэй материалыг газрын гадаргуугаас дээш давхарт байрлах бүх өрөөний цонхонд суурилуулна.
 22. Хурлын өрөөнд аваарын дохиолол суурилуулах.
 23. Цэвэрлэгээний багийг ямар ч үед шүүгчийн өрөөнд хараа хяналтгүй орохыг хориглоно. Цэвэрлэгээг зөвхөн өдөр хийх ба шөнийн цагаар хог хаягдлыг түгжээтэй өрөөний хаалганы гадна орхино. Цэвэрлэгээний багийнхан цэвэрлэгээ хийх үед шүүгч буюу шүүхийн ажилтнууд өрөөнд заавал байх ёстой.

2-5: Шүүхийн байранд нэвтрэх боломжтой хүмүүс

Нэгдүгээр үе шат

1. Олон нийт шүүхийн байранд нэвтэрч орох ганц гол хаалгатай байна. Аюулгүй байдлын үүднээс гол хаалганд бүх хүнийг нэгжинэ гэсэн таних тэмдэг байрлуулах. Энэ тэмдэглэгээнд мөн барилгад оруулахыг зөвшөөрдөггүй зүйлсийн жагсаалтыг багтаасан байна.
 - Бусад бүх хаалгыг байнга түгжээтэй байлгах, ажлын цагийн үеэр ч гэсэн.
 - Аваарын гарцыг бүх гадна хаалган дээр байрлуулна. Бүх хаалга 10 секундйн хоцрогдолтой, орон нутгийн кодтой түгшүүрийн дохиотой байна. "Зөвхөн гарах" гэдгийг тайлбарласан тэмдэглэгээг бий болгох.



- Өглөө шүүхийн байгууламж олон нийтэд нээлттэй болохоос өмнө, орой барилгын бүх хэсэг хаагдсаны дараа, шүүхийн байрны аюулгүй байдлыг хянаж байна.
2. Аюулгүй хаалгаар нэвтрэн орох протоколыг бий болгох.
 - Барилгын аль нэг хаалгыг дараах хүмүүсийн нэг нь эсвэл хэд хэд нь карт эсвэл түлхүүрээр нэвтрэн ашиглаж болно: шүүгчид, шүүхийн ажилтнууд болон бусад барилгын түрээслэгчид. Өмгөөлөгч болон иргэдийн төлөөлөгчид энэ хаалгаар орж болохгүй, зөвхөн нийтийн хаалгаар орох ёстой.
 - Аюулгүй хаалгаар орохдоо ажилчид өөр хүмүүсийг (хамтран ажиллагсад, гэр бүлийн гишүүд, найз нөхөд гэх мэт) дагуулж орохыг хориглох бодлого, журмыг боловсруулах хэрэгтэй. Аюулгүй хаалгаар нэгэн зэрэг хамт олон хүн орж болохгүй. Өөрөөр хэлбэл хүн бүр картаа уншуулан орно.
 3. Шүүхийн байрны гол хаалгыг хамгаалах бүтэн цагийн ШАБА-г ажлуулах.
 4. Хяналтын станцын загварыг барьж байгуулах хүртэл, хяналт хийх газар болгон ашиглах боломжтой түр зуурын ширээ болон бусад бороохойн уяа, хуваагч гэх мэт зүйлсийг байршуулах. Үзлэгийн цэгээс харагдах шугамууд болон барилгын орц/гарц аюулгүй байдлын хариу үйлдэлд нөлөөлөхгүй эсэхийг баталгаажуулах.
 5. Нийтийн хаалгаар нэвтрэн орж ирж буй хүмүүсийг галт зэвсэг байгаа эсэхийг тусгай төхөөрөмж, мөн гараар шалгадаг.
 - Шалгагч нь хяналтын төвтэй радиогоор холбогдох.
 - Шалгагч нь зэвсгийг таних графиктай байх.
 - Шалгагч нь гаалийн бус зүйлсийн жагсаалттай байх.
 - Шалгагч нь шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааны жагсаалттай байх.
 - Шалгагч нь шүүгчид, шүүх болон бусад шүүхийн ажилтнуудын холбоо барих дугаартай байх.
 6. ШАБА-г нэгдүгээр үе шатны бүх даалгаварт сургах.
 7. Шүүгч, ажилтнуудад шүүхийн үндсэн чиглэлийн талаар сургалт явуулах.
 8. Шүүхийн байр бүр нь олон нийтийн анхаарал татсан хурлын үе, эсвэл бусад тусгай нөхцөл байдалд ашиглах боломжтой хамгийн багадаа нэг соронзон хэмжүүртэй байх ёстой.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

9. Гол хаалганд (нийтийн орох хаалган дээр) соронзон хэмжүүр суурилуулах.
10. Системийн үйлдвэрлэгчийн тодорхойлолтын дагуу, соронзон хэмжүүрийг өдөр тутам туршин, шалгах. Шаардлагатай үед соронзон хэмжүүрийг дахин тохируулна. Үүнийг сургалтад суусан хүн хийх ёстой.
11. Хоёрдугаар шатанд нэмэгдсэн бүх ажил үүрэгт ШАБА-г сургаж, шүүгч, ажилтан, шүүхийн гишүүд ба бусад хүмүүст аюулгүй байдлын нэмэлт сургалтыг өгнө.
12. Шүүгч, шүүх эрх мэдэл бүхий ажилтнууд болон барилгын бусад түрээсийн ажилтнуудын шүүхийн барилгын түлхүүрүүдийг нэвтрэх картаар солих. Нэвтрэх картыг шүүхийн аюулгүй байдлын "шаардлагын дагуу" хязгаарлах ёстой. Түлхүүр ашиглагдах үед, давхардсан хувилсан эсэхийг шалгаарай. Бүх карт, түлхүүрийн



жагсаалтыг боловсруулах. Аливаа ажил эрхлэлт дуусгавар болсны дараа картыг идэвхгүй болгож, карт эсвэл гол эзэмшигч нь шүүхийн байранд байрлах сүүлийн өдөрт түлхүүрүүдийг буцааж өгнө.

13. Гол хаалган дээр (нийтийн орох хаалган дээр) аюулгүй байдлын камер суурилуулах.
14. Шүүгч, шүүхийн ажилтан, өмгөөлөгчийн орох хаалганд аюулгүй байдлын камер суурилуулах.
15. Түгжээтэй гадна хаалганд хоёр талын аудио бичих боломжтой аюулгүй байдлын камер суурилуулах.
16. Хоёр дахь ШАБА* эсвэл гэрээт аюулгүй байдлын ажилтныг өдрийн их ачааллын үед гол хаалган дээр ажлуулан туслалцаа үзүүлэх. Өдөр хоёр дахь ШАБА нь заримдаа дотор болон гадаа явган эргүүл хийж, шүүхийн танхимд аюулгүй байдлын хяналт хийж, шүүгч ба эрх бүхий ажилтны орох хаалгыг хянаж байх хэрэгтэй.
17. Шүүхийн байранд орох магадлалтай аюултай хүмүүсийг мэддэг байхын тулд ажилтнууд хууль сахиулах байгууллага, шүүхийн хоорондын шууд харилцаа холбоог бий болгох.
18. Хяналтын станцад дохиолол, утас, буу түгжих шүүгээг нэмэх.
19. Шүүхийн аюулгүй байдлыг хариуцдаг хууль сахиулах ажилтнууд эсвэл зөвшөөрөгдсөн этгээд барилга дотор зэвсэг авч явахыг зөвшөөрөх бодлого бий болгох. Шүүхийн байранд орж ирж буй албан хаагчид (дүрэмт хувцастай, энгийн хувцастай аль алиин) зэвсэг оруулж болохгүй бөгөөд зэвсгийг хяналтын станцад байрлах түгжээтэй шүүгээнд хадгална. Энгийн хувцастай офицерууд албан ёсоор ажилдаа гарч байгаа үедээ нуугдмал зэвсгийг шүүхийн байранд тээж байгаа бол таних тэмдэгтэй байх ёстой.

** Тайлбар: Хоёрдугаар үе шатны боловсон хүчин нь хяналтын станцад байнга ажиллах ба, нэмэлт ШАБА нь ачаалал ихтэй үед байна.*

Гуравдугаар үе шат

- 1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
 20. Гол хаалганы хяналтын станцад рентген зураглалын систем суурилуулах.
 21. 16-р шатанд дурдсан хоёр дахь ШАБА эсвэл гэрээт аюулгүй байдлын ажилтан олон нийтийн орох хэсгийн хяналтын станцад байнга ажиллана. Хүн багатай үед, хоёр дахь ШАБА эсвэл гэрээт аюулгүй байдлын ажилтан нь 16-д тайлбарласан нэмэлт үүрэгт бэлэн байна.
 22. ШАБА болон гэрээт аюулгүй байдлын ажилтанг бүх үүрэг даалгаврыг гүйцэтгэхийг зааж, шүүгчид болон ажилтнуудад аюулгүй байдлын чиг баримжаа олгох сургалт явуулна.
 23. Хүргэлтийн хүмүүс ба гэрээт ажилчид гол хаалгаар орох ёстой ба мөн хүргэлт буюу үйлчилгээг авах эрх бүхий төлөөлөгч баталгаажуулна. Хүргэлтийн хүмүүс болон илгээмжийг соронзон хэмжүүр болон рентген машинаар шалгана. Эдгээр хүргэлт хийж байгаа хүмүүс ба гэрээт ажилчид гол хаалганд шалгуулсны дараа өөр гадна хаалгаар орж гарч үйлчилгээ эсвэл хүргэлт хийх шаардлагатай бол мөн адилхан



журам дагаж мөрдөх ёстой. Эдгээр хүмүүс дотор байхад хамгаалагчид дагалдан удирдан явна.

24. Хяналтын станцын ажилчид баллистик тэсвэртэй хантааз заавал өмссөн.
25. Хяналтын станцын ажилчдыг хамгаалахын тулд баллистик хамгаалалттай халхавч суурилуулах.
26. Гурав дахь шатны үйл ажиллагаанд нэмэлт бодлого, журмыг дараах байдлаар тогтооно:
 - Жил болгон рентген зураглалын системийг шалган баталгаажуулах. Энэ төхөөрөмж улсын эрүүл мэнд, аюулгүй байдлын агентлагуудад бүртгэгдсэн байх ёстой.
 - Орчин үеийн хяналтын журмыг нарийвчлах, алхам алхмаар дагаж мөрдөх гарын авлагатай болгох, сургалт хийх, тасралтгүй боловсруулах.

**Тайлбар: Гуравдугаар үе шатны боловсон хүчин нь хяналтын станцад байнга ажиллах 2 хоёр ажилтантай байх ба тэдний нэг нь заавал ШАБА байна.*

Шилдэг туршлага

- 1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
 27. Нийтийн хаалганы хяналтын станцын 3 дахь ШАБА ажилтныг томилох: нэг нь соронзон хэмжүүрийг ажиллуулах, нэг нь рентген зураглалын системийг ажиллуулах, гурав дахь нь асуудлыг шийдэж зохицуулалт хийх. Хүн багатай үед гурав дахь ажилтан үүрэг гүйцэтгэх боломжтой. Ер нь бүх ШАБА-д зэвсэглэсэн байх ёстой, гэхдээ наад зах нь зэвсэглэсэн л байж болно. Бүх хяналтын ажилчид үхлийн аюулгүй хамгаалалт зэвсгээр зэвсэглэгдсэн байна. Бүх хяналтын ажилчид биедээ камер, радио холбооны тоног төхөөрөмжтэй байх ёстой.
 28. Хэрэв хоёр ба түүнээс дээш олон нийтийн хяналтын станц ажиллаж байгаа бол дөрөв дэх ШАБА-г үйл ажиллагаанд хяналт тавихын тулд ахлагчаар томилно.
 29. Шүүгчийн орох хаалганд соронзон хэмжүүр, рентген зураглалын систем, аваарын дохиолол, хяналтын камер суурилуулах. Шүүхийн төлөөлөгчид энэ хаалгыг ашиглаж болно.
 30. Хэрэв өдрийн оргил цагаар энэ хаалгаар шүүгч, шүүхийн төлөөлөгчид, ажилтнууд орж гардаг бол, аюулгүй байдлын хоёр ажилтан (дор хаяж нэг нь ШАБА байх ёстой). Хэрэв үгүй бол дор хаяж нэг ШАБА байна.
 31. Нийтлэг хяналтын бодлого бий болгох. Нийтлэг хяналтын бодлого гэдэг нь барилгад нэвтрэх хүн бүрийг шалгах ёстой гэсэн үг. (гэсэн хэдий ч шүүгч нарт зориулсан тусгай хаалга байхгүй тохиолдолд, шүүгч нар нийтийн хаалган дээр дараалал хүлээх ёсгүй).

**Тайлбар: Энэ шатны боловсон хүчин нь хяналтын станц болгонд байнга ажиллах гурван ажилтантай байх ба тэдний хоёр нь заавал ШАБА байна. Мөн бүх станцыг удирдах нэг ШАБА ажилтан ба шүүгч, шүүхийн төлөөллийн хаалгыг хариуцах хоёр хамгаалалтын ажилтан байна (тэдний нэг нь заавал ШАБА байна).*

Хяналтын станцын шилдэг туршлагын элементүүд

- Рентген машин болгонд хоёр соронзон хэмжүүр



- Хяналтын станц болгонд гурван хамгаалалтын ажилтан байнга ажиллах, тэдний хоёр нь заавал ШАБА байна
- Хүний холхилдсоноос хамааран зөв хангалттай хэмжээтэй байх
- Дараалж зогсох эгнээ нь зүй зохистой байх
- Орох, гарах эгнээ нь тодорхой, тусдаа байх
- Баллистик тэсвэртэй хантааз, халхавч
- Аюулгүй байдлын камер
- Аваарын дохиолол
- Хүмүүс шалгуулсныхаа дараа өөрсдийгөө янзлах ширээ/сандал хяналтын станцаас хол байх

2-6: Нийтийн үйлчилгээний хэсэг, оффис

Нэгдүгээр үе шат

1. Нийтийн үйлчилгээний хэсэгт нэг ба түүнээс дээш аваарын дохиоллыг суурилуулах. Ажилчдад аваарын дохиоллын функц, ашиглах протоколыг заах.
2. Гаднаас нь хүн ажиглуулахгүй байхын тулд өрөөнүүдийн цонхны хучилтыг байнга хаалттай байлгах.
3. Бэлэн мөнгөний тоолуурын хэсгийн ширээг Plexiglas™ төрлийн хаалт суурилуулах.
4. Бэлэн мөнгө, чекүүдийг шөнөдөө аюулгүй, түгжээтэй газар байлгах
5. Нийтийн үйлчилгээний хэсгийн ширээг даван үсрэх, авирах оролдлогыг хязгаарлахын тулд бүх ширээг хангалттай өндөр ба өргөн байлгах.
6. Нийтийн үйлчилгээний хэсгийн ойролцоо олон нийтэд зориулсан сандал байгаа бол сандал нь шаланд бэхлэгдсэн, эсвэл хоорондоо холбоотой эсэхийг шалгах.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

7. Нийтийн үйлчилгээний бүх хэсэгт поликарбонат (ж.нь Plexiglas™) хашлага суурилуулах. Хэрэв шүүхийн барилгад хяналтын хэсэг байхгүй бол, эсвэл хяналтын хэсэг материалын дутагдалтай бол, үйлчилгээний ширээний дээд доод хэсэгт баллистик тэсвэртэй хашлага байрлуулна.
8. Танхимын арын хэсгээр стратегийн үүднээс аваарын дохиолол суурилуулах.
9. Бүх хурал хэлэлцүүлгийн өрөөнд аваарын дохиолол суурилуулах. Хурал хэлэлцүүлгийн өрөөний тавилгыг аюулгүй байдлын үүднээс харгалзан байршуулах. Жишээлбэл, ажилчдын орох гарах хаалгыг зочны сандал хааж саад болох ёсгүй.
10. Бэлэн мөнгө, чекүүдийг шөнөдөө аюулгүй, түгжээтэй газар байлгах.
11. Сөрөг үйл явдлын үед шүүгч болон ажилчдын аюулгүй байдлыг сахих үүднээс шүүхийн байранд аюулгүй өрөө бий болгох. Дотроосоо түгжиж, түгжээг тайлж болох механизмын өөрчлөлт оруулах. Хаалгыг өшиглөхөөс хамгаалахын хаалганы тотгыг бэхлэх. Аюулгүй өрөөнд аваарын дохиоллыг суурилуулах.
12. Олон нийтийн ариун цэврийн өрөөг ашигладаг ажилчдад зөөврийн аваарын дохиоллыг өгөх.

Гуравдугаар үе шат

1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:



13. Нийтийн үйлчилгээний бүх хэсэгт байгаа хүмүүсийн царай харагдах маягаар хяналтын камер суурилуулах.
14. Сейфэнд зохих дохиолол болон мэдрэгч (жишээ нь: аюулгүй байдал, утаа, гал, хэт чийглэг, хөдөлгөөн) суулгах.
15. Хамгаалалт хэрэгтэй хүмүүс, түүнчлэн халдлагад өртөж болзошгүй бусад хохирогч, гэрч нарт аюулгүй, найдвартай хүлээлгийн хэсгээр хангах.

Шилдэг туршлага

- 1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
 16. Бүх сейф харагдах хяналтын камер суурилуулах.
 17. 24/7 турш дотор хэсэгт хуваарьт эргүүл хийхийг шаардах.
 18. Бүх хурал хэлэлцүүлгийн өрөөний хаалга шилэн хэсэгтэй байх.

2-7: Шүүгчийн машины зогсоол

Нэгдүгээр үе шат

1. Шүүгчдийн нэр эсвэл цолоор тодорхойлох бүх тэмдгүүдийг шүүгчийн машины зогсоолоос авах. Аливаа тэмдэглэгээ нь зөвхөн зохих тооны дагуу урьдчилан захиалсан гэсэн тэмдэгтэй байна.
2. Өглөө шүүгч нар хамгаалагдаагүй авто зогсоолд зогссон бол, хууль сахиулах ажилтан эсвэл өөрт нь томилогдсон ШАБА-д ирснээ мэдэгдэн, хамгаалуулан орно.
3. Ажлаа тарахдаа, хүсэлт гаргавал, шүүгч нар өөрт нь томилогдсон ШАБА-р хамгаалуулан хамгаалагдаагүй зогсоолруу очиж болно.

Хоёрдугаар үе шат

- 1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
 4. Тоосго, чулуу гэх мэт гэрэл нэвтэрдэггүй материал ашиглан шүүгчийн зогсоолыг хаших. Хэрэв энэ нь боломжгүй бол, гинжин холбоостой төмөр хашаа ашиглана. Хашаагаа доторхыг нь харагдуулахгүй зүйлээр бүрнэ.
 5. Яллагдагч нарт шүүгч машинаасаа орж гарч байгааг огт харуулж болохгүй.
 6. Авто зогсоолд зохих хэмжээний гэрэлтүүлэг суурилуулах.
 7. Өндөр аюул заналхийлсэн, аюулгүй байдлын асуудалтай үед, шүүгчид нь өөрийн болон бусад тээврийн хэрэгслээс хамгаалагчтай орж гарах.
 8. Шүүгчийн авто зогсоол нь зохих хэмжээний хамгаалалт, гэрэлтүүлэгтэй байна.
 9. Хаалга, хашааг удаан хугацааны туршид нээлттэй байлгахгүй үүднээс хамгаалалттай авто зогсоолын хаалга, хашааны нээгдэх, хаагдах цагийг тохируулах.

Гуравдугаар үе шат

- 1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
 10. Авто зогсоолд түргэн дуудах утасны бүхээг болон аюулгүй байдлын камер суурилуулах.
 11. Өглөө, өдрийн цайны цагаар, ажил дуусах үеэр шүүгч болон шүүхийн ажилтнуудыг харгалзан ШАБА тогтмол эргүүл хийж байх.



12. Карт эсвэл бусад тохирох төхөөрөмж ашиглан авто зогсоолд нэвтрэн орох аюулгүй байдлын саадуудыг суурилуулах.

Шилдэг туршлага

1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлийг нэмнэ:

13. Хамгаалалтын зорилгоор хаалттай машины зогсоолын талбайг илүү тохиромжтой байлгах үүднээс шүүгчдэд машинаасаа шууд шүүхийн байгууламжруу харуул хамгаалалтын хяналтаар дамжин олон нийтийн газар эсвэл шүүхийн гол хаалганы орох талбайд нэвтрэхгүйгээр өөрсдийн танхимд орох боломжийг хангах.

2-8: Эргэн тойрон дахь асуудлууд

Нэгдүгээр үе шат

1. Шүүгч нарт зориулсан машинаасаа шууд шүүхийн танхим руу орох боломжтой халхавчтай аюулгүй зогсоолын газар бий болгох. Шүүхийн барилгад ямар зүйлс авчирч болохгүйг (жишээ нь, буу, хутга, хайч), мөн аюулгүй байдлын үүднээс үзлэг хийх утгатай сэрэмжлүүлэх тэмдэглэгээг тавих.
2. Барилгын эргэн тойрон болон авто зогсоол хангалттай гэрэлтүүлэгтэй байх. Харанхуйд шүүгч, ажилчид орж гарахад аюулгүй байх түвшний гэрэлтүүлэгтэй байх. Түүнчлэн хяналтын камер барилгын эргэн тойрны зургийг хангалттай авах чадвартай байх.
3. Ажлын бус цагаар хаалга түгжээтэй байлгах, зөвхөн эрх бүхий түлхүүр эсвэл картаар нэвтрэх боломжтой байх.
4. Нуугдмал талбайг хязгаарлах, эд хөрөнгийн хохирлыг урьдчилан сэргийлэх, нууцаар нэвтрүүлэхгүй байх үүднээс мод, бут сөөгийг зохих ёсоор тохижуулан байгаль орчны дизайнаар дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
5. Барилгын эргэн тойронд, ялангуяа барилга хаалттай байх үед байнга аюулгүй байдлын шалгалт хийх.
6. Олон нийтэд хязгаарлагдмал газрыг тэмдэглэгээгээр заасан байх.
7. Зэвсэг нууж эсвэл аюултай материал болгон ашиглаж болох бүх хогийн сав, сонингийн тавиур, бусад зүйлсийг шүүхийн байрнаас хол зайд аюулгүй газар нүүлгэн шилжүүлэх.
8. Шүүхийн эргэн тойрны талбай бүхэлдээ нээлттэй тодорхой харагдаж байгаа эсэхийг сайтар шалгах.
9. Анхны тусламж үзүүлэгчдэд нүүлгэн шилжүүлэхэд хангалттай зай байгаа эсэхийг шалгах.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

10. Бүх гадна хаалга, хүрч болохуйц цонхонд халдлага илрүүлэх систем суулгах.
11. Бүх өдрийн турш тогтмол бус цагаар ШАБА гадна хэсгээр эргүүл хийх.
12. Цонхыг халхавч эсвэл баллистик тэсвэртэй материал ашиглан гаднаас халдлага хийх эрсдэлийг багасгах.

Гуравдугаар үе шат



- 1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
13. Барилгын эргэн тойронд (барилгын булан болгонд) хяналтын камер суурилуулах. Камерт шүүхийн байрны бүх хэсэг харагдах ёстой.
 14. Сонгосон гол гадна хаалга, тээвэрлэлт, түгээлтийн тавцан, доод давхрын том цонх, болон бусад эмзэг аюултай газруудад машины хөдөлгөөнд саад болдог металл бетон багана суулгах.
 15. Шүүхийн барилгын зогсоол эсвэл ойролцоо байрлах машины зогсоол, эсвэл “тэсэрч болохуйц” хэмжээнд тээврийн хэрэгслийг зогсохыг хориглох.
 16. Бүх ил задгай хий, цахилгаан болон бусад хэрэгслүүдийг нийтэд ойр байлгахгүй. Агааржуулалтын суваг болон бусад нүхнүүдийг физик халдлага болон хортой бодисонд өртөхөөс хамгаалах.
 17. 24/7 турш гадна хэсэгт хуваарьт эргүүл хийхийг шаардах.

Шилдэг туршлага

- 1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
18. Гол хаалганд хяналтын ажилчдад дотроосоо харагдах боловч, гаднаасаа олон нийтэд харагдахгүй толин тусгалтай шил суурилуулах.
 19. Гадна хаалганы бүх түлхүүрийг электрон карт уншигчтай системээр (онцгой байдлын гарах хаалганаас бусад) солих.
 20. Шүүхийн эргэн тойрон дахь авто зогсоолд түргэн дуудах утасны бүхээг болон аюулгүй байдлын камер суурилуулах.





ГУРАВ. ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГТЭЙ ЗҮЙЛС

3-1: Шүүхийн байранд ажлын цагийн дараа нэвтрэх

Нэгдүгээр үе шат

1. Шүүхийн бүх байранд зөвхөн түлхүүр буюу цахим картаар нэвтрэх. Шүүхийн аюулгүй байдлын хорооноос батлагдсан хариуцлагын тогтолцооны дагуу түлхүүр, картыг олгохдоо сайтар хянах. Аливаа этгээдэд түлхүүр буюу нэвтрэх карт өгөхөөс өмнө тэр хүний талаар бүх мэдээллийг аван шалгалт хийх. Энэхүү шалгалтыг тус хүнийг ажилд орохын өмнө эсвэл гэрээ гүйцэтгэхийн өмнө хийнэ. Ажлын бус цагаар нэвтрэхийг аль болох хязгаарлана. Ая тухаа бодон сайн хамгаалалтыг умартаж болохгүй.
2. Ажлын бус цагаар ажилладаг цэвэрлэгээний багийн гишүүд болон худалдагч, бусад ажилчдын мэдээллийн талаар жил болгон шалгалт хийх.
3. Ажлын бус цагаар цэвэрлэгээний багийн гишүүд болон худалдагч нарыг нэвтрэхэд шүүхэд хариуцлага хүлээх чадвар бүхий хүн цаг ямагт хяналт тавина. Боломжтой бол, шүүхийн өрөө, танхимыг ажлын өдрөөр цэвэрлэж, ажлын бус цагаар ажиллуулахгүй байвал тохиромжтой. Цэвэрлэгээний багийг шүүгчийн өрөөнд ганцаараа ажиллахыг огт зөвшөөрөхгүй.
4. Олон нийт ажлын бус цагаар барилгад байх шаардлагатай үед тэдний үйл ажиллагааг баримтжуулж, хянах. Ажлын бус цагаар шүүхийн барилгад зөвшөөрөгдөөгүй хүмүүс байлгахгүй байх бодлого, журам тогтоох.
5. Аливаа ажилтны ажил эрхлэлт дуусгавар болоход нэвтрэх картыг идэвхгүй болгож, түлхүүрийг нь ажлын сүүлийн өдөр буцаан авна. Энэ нь эцсийн цалин олгохоос өмнө болох ёстой.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлийг нэмнэ:

6. Түлхүүрийг ашиглахын оронд, картын системийг ашиглах. Онцгой тохиолдлуудад түлхүүр шаардлагатай үед яаралтай тусламжийн зориулалтаар нэмэлт түлхүүрийг хадгалан, хувилаагүй түлхүүр өгнө.

Шилдэг туршлага

1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

7. Ажлын цагаар хүмүүсийг шүүхийн байранд ШАБА-р хамгаалагдсан зөвхөн нэг хаалгаар оруулж, тэр хүний бичиг баримтыг хураан авч, гарын үсэг зуруулан нэвтрэх эрхийг олгоно.
8. Орж ирэх бүх хүмүүст аюулгүй байдлын шалгалт хийнэ.

3-2: Онцгой байдлын тоног төхөөрөмж

Нэгдүгээр үе шат

1. Шүүх, албан тасалгаа, олон нийтийн газруудад зайгаар ажилдаг яаралтай тусламжийн гэрэлтүүлгийн системийг байрлуулна.
2. Давхар болгонд гал унтраагч, гарцуудыг тэмдэглэсэн давхрын төлөвлөгөө байрлуулсан байна.



3. Давхар болгонд дохиолол суурилуулна.
4. Шинэчлэгдсэн, бүх галын кодтой цахилгаан шатыг суурилуулна.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

5. Хашсан хамгаалагдсан яаралтай тусламжийн генераторын системийг суурилуулна.
6. Генераторын системийг сар бүр турших; туршилтын бүртгэлийг хадгалах.
7. Яаралтай тусламжийн генератор хэр саатаж байгааг тодорхойлох, чухал системүүдэд тасралтгүй тэжээлийн хангамж (ТТХ) суурилуулах.
8. Шүүхийн байрны давхар болгонд автоматжуулсан гаднах дефибриллятор (АГД) суурилуулах.

Шилдэг туршлага

1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлийг нэмнэ:

9. Галын дохиоллын системийг стробскоп болон пускателаар тоноглогсон байх.

3-3: Халдлага илрүүлэх систем

Нэгдүгээр үе шат

1. Гаднах бүх хаалганууд үндсэн халдлага илрүүлэх дохиоллын төхөөрөмжтэй байна, үүнд:

- Ажлын болон ажлын бус цагаар барилгад орох/гарах.
- Ажлын болон ажлын бус цагаар онцгой байдлын гарах хаалга.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны алхмыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлийг нэмнэ:

2. Бүх хүрч болохуйц цонхон дээр халдлага илрүүлэх дохиоллын төхөөрөмж, подвалд, нэг давхарт, магадгүй 2-р давхарт шил хагарах юм уу хөдөлгөөн мэдрэгч суулгах. Үүнийг, хүрч болохуйц цонхонд хөдөлгөөн мэдрэгчтэй дохиоллыг, өрөөн дотор идэвхгүй хэт улаан туяаны мэдрэгч суурилуулан хийж болно.

Гуравдугаар үе шат

1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

3. Дараах функцтэй халдлага илрүүлэх цогц системийг бий болгох:

- Шүүхийн барилга хаалттай байх үед, бүх гадна хаалга халдлагад өртсөн хэсгийг тогтоох, хяналтын төвд дохиолол идэвхжүүлдэг төхөөрөмжөөр тоноглогдсон байх ёстой.
- Ажлын цагаар түгжээтэй бүх хаалгыг халдлагад өртсөн хэсгийг тогтоох, хяналтын төвд дохиолол идэвхжүүлдэг төхөөрөмжөөр тоноглох ёстой. Онцгой байдлын гарцтай түгжээтэй бүх хаалгыг ашиглах болгонд 10 секундйн хоцрогдолтой дохиолол дуугарч байна.
- Шүүхийн барилга хаалттай байх үед, дохиолол нь зохих хууль сахиулах байгууллагын хяналтын төвд очно; барилга нээлттэй үед дохиолол нь барилгын хяналтын төвд очно.



- Халдлага илрүүлэх дохиоллын систем нь дохиол байгаа талбайд мөн түүнчлэн хяналтын төвд сонсогдох ёстой (эсвэл шүүхийн хяналтын төвд ажилчид байхгүй тохиолдолд түргэн тусламжийн диспетчерийн төвд).

Шилдэг туршлага

1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлийг нэмнэ:

4. Аюулгүй байдлын камер халдлагад өртөх хэсэгт идэвхжүүлэхийн тулд камерыг дээр дурдсан системд нэгтгэх.

3-4: Ажлын цагаар дотогш нэвтрэх (эргэлтийн бүс)

Нэгдүгээр үе шат

1. Шүүхийн танхим дотор боломжтой гэж үзвэл дараах байдлаар эргэлтийн бүсийн концепц бий болгох:
 - Шүүгч болон шүүхийн ажилтнууд (жишээ нь, өрөө, захиргаа, шүүхийн төлөөлөгчдийн хэлэлцүүлгийн өрөө, хурлын өрөө, нийтийн үйлчилгээний ажилчдын хэсэг, хувийн цахилгаан шат, аюулгүй шат).
 - Яллагчдыг тээвэрлэх (жишээ нь, шүүхийн барилга, шүүх хурал болох газар/ хэсэгрүү орох, гарах зам).
 - Нийтийн хэсэг (жишээ нь, олон нийтийг нийтийн бүсээс хязгаарлах).
2. Шүүхийн эргэлтийн бүсийн концепцийн дагуу бүх хаалга хаалттай байна. Ийм хаалгыг хэзээ ч нээлттэй үлдээх ёсгүй.
3. Хэн аль хэсэгт нэвтрэх боломжтойг захиргаанаас баталсан тогтолцоон дээр суурилан түлхүүр эсвэл нэвтрэх картын систем ашиглан нэвтэрч орно. Карт, түлхүүрийг ая тух биш хэрэгцээн дээр үндэслэн олгоно. Түлхүүр нь хоёр ширхэг байх ба хувилж, олшруулсан түлхүүр байх ёсгүй. Энэ систем нь:
 - Төв байгууллагын хяналтан дор.
 - Бүх карт, түлхүүр эзэмшигчдийн мэдээллийг шалгах шаардлагатай.
 - Нөхцөл байдал өөрчлөгдсөн үед (жишээ нь: ажил эрхлэлт дуусгавар болох) түлхүүрийг буцааж авах эсвэл картыг хүчингүй болгох журмыг оруулах.
 - Байнга нэвтрэх карт болон түлхүүрийн тооллого хийж байх.
4. Ажил эрхлэлт дуусгавар болоход ажлын сүүлийн өдөр картыг хүчингүй болгох, түлхүүрийг буцааж авах ба энэ нь эцсийн цалин олгохоос өмнө хийгдсэн эсэхийг баталгаажуулах.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

5. Түлхүүр ашиглахгүй байх, нэвтрэх карт хэрэглэх. Засвар үйлчилгээний ажилтнууд болон яаралтай тусламжийн ажилтнууд түлхүүрийг авч үлдэх.
6. Нэвтрэх карт дээр эзэмшигчийнх нь зураг байх, үүгээр хяналтын ажилтан тэр хүнийг тухайн картын жинхэнэ эзэмшигч мөн болохыг мэднэ. Ийм учир, нэвтрэх карт эзэмшигчийн зурагтай байх ёстой.
7. Зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэхийн тулд шүүхийн танхимын хаалганд дуран байрлуулах.



Гуравдугаар үе шат

- 1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
8. Аюулгүй хэсгийг хянах видео харилцаа холбоо болон алсын удирдлагатай соронзон хаалганы систем бий болгох.
 9. Эргэлтийн бүсийг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
 10. Сэжигтэй үйл ажиллагаа болон зохисгүй, заналхийлсэн зан үйлийг хянахын тулд шүүхийн байгууламжийн бүх аюулгүй хэсэгт аюулгүй байдлын камерын систем суурилуулах.

Шилдэг туршлага

- 1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
11. Хамгаалалттай хэсэгт нэвтрэхийг зөвшөөрөх видео харилцаа холбоо болон алсын удирдлагатай соронзон хаалганы систем бий болгох. Бүсүүдийн хооронд бүрэн тусгаарлалтыг бий болгох (жишээ нь, яллагдагч нар хамгаалалттай эсвэл олон нийтийн танхимаар явахгүй байх; шүүгчид машинаас шүүхийн байранд орох гарахад, олон нийтийн газраар дамжин өнгөрөхгүй байх). Шаардлагатай гэж үзвэл аюулгүйн бүсүүд босоо давхарт (дээд давхраас доош давхар), хэвтээ байдлаар (адил давхарт) байрлах ёстой.

3-5: Нийтийн хүлээлгийн танхим, коридор, шат, цахилгаан шат

Нэгдүгээр үе шат

1. Шүүхийн байранд нөөц үүсгүүртэй гэрэлтүүлэг, онцгой байдлын гарах тэмдэг зэрэг онцгой байдлын гэрэлтүүлэг бэлтгэх.
2. Шатны хонгил, коридор, цахилгаан шатаар орж гарах талаарх стандартыг бий болгох. Шүүхийн ихэнх байгууламжид, шатны хонгилоор дамжин гарсан хүмүүст дахин нэвтрүүлж болохгүй. Шатны хонгилоор орж ирсэн бол заавал нэвтрэх зөвшөөрөлтэй байна. Шүүхийн байгууламж "өндөр зэрэглэлийнх" бол аюулгүй байдлын үнэлгээ болон амьдралын аюулгүй байдлын шинжилгээгээр зарим давхарт дахин нэвтрэх боломжийг олгож болно.
3. Онцгой байдлын журам ба нүүлгэн шилжүүлэлтийн диаграммыг бий болгох. Шүүхийн байрны хонгилд тэр давхрын диаграммыг байршуулах.

Хоёрдугаар үе шат

- 1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
4. Аюулгүй, нийтийн цахилгаан шатыг бий болгох.
 - Шүүгчийг аюулгүй лифтээр хангах
 - Яллагдагчийг аюулгүй лифтээр зөөх
 5. Шүүхийн байраар ялангуяа хөл хөдөлгөөн ихтэй газраар ШАБА байнга эргүүл хийх.

Шилдэг туршлага

- 1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:
6. Шүүхийн байрны нийтийн хүлээлгийн танхим, коридор, шат, цахилгаан шатанд хяналтын камер суурилуулах. Аюулгүй цахилгаан шатаар нэвтрэх картаар зорчино.
 7. Тодорхой хуваарийн дагуу эдгээр газраар ШАБА байнга эргүүл хийж байх.



8. Зарлал, онцгой байдлын кодыг хялбарчлахын тулд барилга дотор олон нийтэд зориулсан хаягийн систем байршуулах.

3-6: Шүүхийн төлөөлөгч нарын аюулгүй байдал ба эргэлт

Нэгдүгээр үе шат

1. Шүүхийн төлөөлөгчдийн хүлээн авсан шүүхийн зарлан дуудах хуудасны мэдээлэлд шүүхийн аюулгүй байдлын мэдээллийг нэгтгэн өгөх. Жишээлбэл:
 - Шүүхийн байранд хаагуур орох.
 - Ямар зүйлсийг (жишээ нь, хутга, хумсны хэрэгсэл, хайч) шүүхийн байранд оруулж болохгүй.
 - Шүүхийн өмнө болон шүүхийн үеэр хэргийн талаар хэн нэгэнтэй хэлэлцэхгүй байх.
 - Шүүхийн байгууламжаас гадна шүүхийн таних тэмдгийг зүүхгүй байх.
 - Хахууль, аюулгүй байдлын асуудлаар хэнд хандах.
2. Шүүхийн байгууламж болон хурлын танхимд орохоос нь өмнө хянан шалгах.
3. Шүүхийн төлөөлөгч нарт шүүхийн танхимд орохоос өмнө үндсэн аюулгүй байдлын болон нүүлгэн шилжүүлэлтийн мэдээлэл өгөх, таних тэмдгийг нь олгох. Онцгой байдлын үед юу хийх, аваарын кодоод хэрхэн хариу өгөх талаар хэлэлцэх. Гадуур таних тэмдгийг зүүж үзүүлэхгүй байхыг сануулах; хэрэв таних тэмдэг нь алга болсон, хаяж гээгдүүлсэн бол хэнд мэдэгдэх зэрэг зааварчилгаа өгнө.
4. Шүүхийн төлөөлөгчдийг шүүх хурлын үеэр болон хэлэлцүүлгийн өрөөнд ШАБА эсвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагынхан хариуцаж байх.

Шилдэг туршлага

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

5. Шүүхийн төлөөлөгчид хэлэлцүүлгийн өрөөнд байх үед гадна дотор нь ШАБА хамгаалж байна.
6. Шүүхийн төлөөлөгчид шүүх хурлын танхимд орох үед ШАБА харгалзаж байна. Хэрэв шүүх хуралд оролцож байгаа шүүхийн төлөөлөгчид нийтээрээ шүүхийн барилгаас гадуур хооллож байгаа бол ШАБА харгалзаж явна. Хэрэв цахилгаан шат ашиглаж байгаа бол нэг ШАБА хамт явж, нөгөө нь буух давхрыг нь хамгаалан зогсоно.
7. Шүүхийн төлөөлөгчдийн хэлэлцүүлгийн өрөө болгонд аваарын дохиолол суурилуулах.
8. Олон нийт ашиглах боломжгүй зөвхөн шүүхийн төлөөлөгчид ашиглах ариун цэврийн өрөө байх.
9. Шүүхийн барилгад орж гарах үед машиндаа зорчих үед аюулгүй байдлыг нь хангах.

3-7: Бэлэн мөнгөтэй харьцах

Нэгдүгээр үе шат

1. Бэлэн мөнгөтэй харьцах журмыг шүүхийн ажилтнуудад боловсруулж, сургах. Үүнд:
 - Мөнгө хураах хүнийг тодорхойлох.



- Өдрийн цагаар болон ажлын бус шөнийн цагаар мөнгө хамгаалах арга замыг тодорхойлох.
 - Чекийг хэрхэн шалгах, төлбөр нэгтгэх талаар ажилтнуудад сургах.
 - Барьцаа мөнгөний стандартыг тогтоож, хэрэгжүүлэх.
 - Мөнгөтэй харьцах ажилтнуудын буух цаг нь өөр байдаг бол, дараах томилогдсон хүмүүст хүлээлгэж өгнө.
2. Мөнгө хураах хэсэгт аваарын дохиолол, хашлага суурилуулах.
 3. Мөнгө хадгалахдаа хамгаалалттай сейф ашиглах.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлийг нэмнэ:

4. Бэлэн мөнгөтэй харьцах хэсэгт хяналтын камер суурилуулах.

Гуравдугаар үе шат

1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлийг нэмнэ:

5. Тусгай автомашины үйлчилгээ эсвэл банкны ажилтнууд өдөр бүр мөнгийг зөөж байх.

Шилдэг туршлага

1, 2, 3-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлийг нэмнэ:

6. Шүүхийн байрнаас бэлэн мөнгө нааш цааш нь зөөхөд хоёр хүн шаардлагатай – нэг шүүхийн ажилтан, нөгөө нь зэвсэглэсэн ШАБА.

3-8: Захидал болон илгээмж шалгах

Нэгдүгээр үе шат

1. Шүүхийн байранд орж байгаа бүх захидал болон илгээмжийн хаяг, сэжиг бүхий зүйлсийг шалгах.
2. АНУ-ын Шуудангийн Үйлчилгээний Алба (USPS)-аас ажилтнуудад шуудангийн хүлээн зөвшөөрөгдсөн цэгүүд, аюулгүй илгээмж таних аргын талаар сургалт явуулахыг шаардах.
3. Илгээмжийг сэжигтэй, эсвэл аюултай гэж тодорхойлсон үед хариу арга хэмжээ авах протоколыг боловсруулах.
4. Захидал/илгээмж илгээгч болон хүлээн авагчдыг баталгаажуулах, захидал/илгээмжийг өөрчилсөн эсэхийн талаар тодорхой бодлого, журам боловсруулах.

Хоёрдугаар үе шат

1-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:

5. Бүх захидал болон илгээмжийг рентген зураглалын системээр шалгахыг шаардах.
6. Бүх захидал болон илгээмжийг хүргэж буй хүнийг соронзон хэмжүүрээр дамжин өнгөрөхийг шаардах.

Шилдэг туршлага

1, 2-р үе шатны бүх алхмуудыг үргэлжлүүлэн дээрээс нь дараах зүйлсийг нэмнэ:



7. Шүүхийн барилгад хүргэгдсэн захидал, илгээмжид зориулж тусад нь хяналтын хэсэгтэй болгох. Жижиг шүүхэд энэ нь тохиромжгүй тул бусад шуудангийн байгууллагуудтай хамтран ажиллаж болно. Том шүүхэд ашиглах дадал:
- Шуудангийн газар, тээвэрлэгчээс ирсэн бүх захидал, багц, илгээмжийг хүлээн авмагцаа сайтар шалгах (сэжигтэй тохиолдолд рентген болон тэсрэх бодис илрүүлэгчээр шалгах). Үүнд шүүхийн ажилтнуудад бүх төрлийн шуудангаар илгээсэн захидал орно.
 - Цэцэг, чихэр, хоол хүнс, бэлэг зэрэг бүх хүргэлтийг илгээмж хянах цэгээр оруулж, шалгаж, хүлээн авагч нь зөвшөөрсөн тохиолдолд хүргэж болно.
 - Илгээмж хянах цэгийн ажилтан бүх ирсэн захидал, илгээмжийг хэлтэс, хэлтсээр ангилж, тухайн шүүхийн эсвэл хэлтсийн томилсон төлөөлөгч хүлээн авна.
 - Төлөөлөгч нь Илгээмж хянах цэгээс захидал, илгээмжээ аван, сэжигтэй илгээмж байгаа эсэхийг дахин шалгаж эзэнд нь тарааж өгнө. Эдгээр төлөөлөгчид сэжигтэй шуудантай холбоотой сургалтад хамрагдсан байх ёстой. Орон нутгийн шуудангийн газар эсвэл шуудангийн байцаагч энэхүү сургалтыг зохион байгуулж болно.

Шилдэг туршлагад багтсан ажилтан, аваарын дохиолол, хяналтын камерын зөвлөмжүүд

Тайлбар: Энд ажилтан, аваарын дохиолол, хяналтын камерын нэгтгэгдсэн зөвлөмжүүд өмнө нь тайлбарласан алхам, үе шат, ангилалд тодорхойлогдсон болно.

ШҮҮХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЖИЛТНЫ (ШАБА) БОЛОВСОН ХҮЧНИЙ ТҮВШИН

Энэ баримт бичигт дурдсан ШАБА нь шүүхийн барилгын аюулгүй байдлыг хангах мэргэшсэн, бие даасан бөгөөд энгийн зэвсэг, тухайлбал, цахилгаан буу, химийн шүршигч, эсвэл баривчлах зэвсэг (тухайлбал, гар, хөлийн гав) хэрэглэх чадвартай хүн гэж тодорхойлно. Зэвсгээ зориулалтын гар бууны гэр дотор хийнэ. Бүх ШАБА хяналтын төвтэй холбогдож чадах радио болон биеийн камертай байна. Хяналтын төвд томилогдсон ШАБА нь заавал галт зэвсэгтэй байх шаардлагагүй.

1. Ажлын цагаар шүүхийн гол хаалган дээр нэг ШАБА байнга байх ёстой.
2. Шүүхийн танхимд яллагдагч байгаа тохиолдолд нэг ШАБА эсвэл тээврийн офицер шүүхийн танхимыг хариуцах ёстой.
3. Нэг эсвэл хэд хэдэн шүүх танхимтай давхарт нэг ШАБА-г томилох, дараа нь нэг шүүх танхимаас нөгөө рүү нь шилжиж болно. Шүүхийн үйл ажиллагаанд яллагдагч оролцсон үед хамгийн багадаа нэг ШАБА эсвэл тээврийн офицер шүүх ажиллагаанд бүхэлд нь оролцох ёстой.

Тайлбар: ШАБА-ны ажлын хэсэг бүрд зохих нэмэлт ажилчид шаардагддаг. Ихэвчлэн өвчтэй байх, жил бүрийн амралт авах, сургалттай үед ээлжлэн нөхөн ажиллах 1.2-1.3 бүтэн цагийн ажилтан байна.

4. Нэмэлт ажилтнууд дараах зүйлийг эн тэргүүнд анхаарна:
 - Хяналтын станцын ажиллах хүчний удирдамжийг хангахын тулд (СЭДЭВ В-5).



- Шүүхийн танхимын ажиллах хүчний удирдамжийг хангахын тулд (СЭДЭВ В-3).
 - Яллагдагчийг тээвэрлэн зөөхөд санал болгосон харьцааг хангахын тулд (СЭДЭВ В-2)
 - Барилгын дотор болон гадна талд эргүүл хийхийн тулд (СЭДЭВ В-8 болон С-5).
5. Дараах сэдвээр санал болгож буй ажиллах хүчний удирдамжийг бүрдүүлэх:
- Хяналтын станцад (СЭДЭВ В-5).
 - Шүүхийн танхимд (СЭДЭВ В-3).
 - Яллагдагчийг тээвэрлэн зөөхөд (СЭДЭВ В-2).
 - Барилгын дотор болон гадна талд эргүүл хийхэд (СЭДЭВ В-8 болон С-5)

АВААРЫН ДОХИОЛОЛ

1. Аваарын дохиоллыг шүүхийн танхим, сандал, хүлээн авах хэсэг, ШАБА-ны станц дээр суурилуулах. Сургалтыг аваарын дохиоллын ажиллагаа болон ашиглах протокол дээр үндэслэн явуулах.
2. Аваарын дохиоллыг дор хаяж сар болгон туршиж байх. Дохиоллын зайг хагас жил болгонд шалгаж байх.
3. Аваарын дохиоллыг өрөө болгонд мөн хүлээн авах хэсэгт байрлуулах (СЭДЭВ В-4).
4. Аваарын дохиоллыг хяналтын станцад байрлуулах (СЭДЭВ В-5).
5. Аваарын дохиоллыг олон нийтийн үйлчилгээний хэсэг, касс болон бусад олон нийтийн нэвтэрч болох газар байрлуулах (СЭДЭВ В-6).
6. Олон нийтийн ариун цэврийн өрөөг ашигладаг ажилчдад зөөврийн аваарын дохиоллыг өгөх (СЭДЭВ В-6).
7. Олон нийт ашиглаж болох өрөөнүүдэд дохиоллыг суурилуулах.
8. Шүүхийн байранд хүүхдийн асрамжийн төв байдаг бол түргэн тусламж дуудах бололцоотой дохиолол суурилуулах.
9. Аваарын дохиоллыг бүх шүүхийн төлөөлөгчдийн өрөөнд байрлуулах (СЭДЭВ С-6).
10. Аваарын дохиоллыг ялтан саатуулах хэсэгт байрлуулах.
11. Аваарын дохиоллыг ачаа тээш ачиж буулгах хэсэгт байрлуулах (СЭДЭВ В-8).
12. Аваарын дохиоллыг шуудангийн өрөөнд байрлуулах.
13. Дохиолол дуугарах үед хамгийн ойрын хяналтын камер ажиглалт, бичлэг хийхэд автоматаар идэвхэждэг байхын тулд аваарын дохиолол болон камерын системийг нэгтгэх.

ХЯНАЛТЫН КАМЕР

Хяналтын камер дараах хүчин чадалтай байна:

- Тодорхой хэсэгт чиглэсэн хүчин чадал. Шүүхийн барилгад уламжлал ёсоор хоёр төрлийн камер хэрэглэдэг байсан (а) дээш доош /хажуу тийш/ татдаг камер, (б) хөдөлгөөнгүй камер. Сүүлийн үед өргөн өнцгийн линзтэй, дээш доош /хажуу тийш/ татах чадвар бүхий өндөр нягтаршилтай дижитал камерууд хэрэглэгдэх болсон ба зарим газарт уламжлалт камерын хэрэглээ багассан. Өргөн өнцгийн камерууд нь



уламжлал камер шиг хязгаарлалтгүй, зорилтот хэсэгт анхаарлаа төвлөрүүлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог (жишээ нь, дээш доош / хажуу тийш / татдаг камер нь Х байршлаас Ү байршилд шилжихэд Х байршилд болж буй зүйл харагдахгүй өнгөрнө).

- Өнгө. Энэ нь одоогийн системийн стандарт юм. Хар цагаан дүрс нь бүрэн түүхийг хэлж чадахгүй. Чухал зүйл нь ялгагдахгүй. Объектыг тодорхой танихад зөвхөн өнгөт дэлгэц тусалдаг.
- Сүлжээний урсгалын багтаамж. Аюулгүй байдлын систем нь видео дүрс дамжуулах, системд нэвтрэх, хянах зэрэг төрөл бүрийн технологи ашиглаж болно. Ихэнх системүүд нь интернэт протокол (IP) ашиглан мэдээллийг дамжуулдаг, сигналыг сүлжээгээр дамжуулан хянах, ИНБ-ууд, анхны оролцогч, шүүхийн ажилтнуудад нэвтрэх боломжийг олгодог өргөн зурвасын холбоос ашиглан ашигладаг. Шүүхүүд өөрсдийн хэрэгцээ, төсөвт тохирсон шинэ дэвшилтэт технологийг эрэлхийлэх, нэвтрүүлэхийг уриалдаг.
- Бичлэгийн хүчин чадал. Камерын систем нь дижитал видео бичлэг хийх хүчин чадалтай, ШАБА нь ослын бичлэгийг дараа дараагийн удаа дахин үзэх боломжтой байх ёстой. Ийм бичлэгийн функц нь гэмт хэрэгтнийг олж тогтооход чухал үүрэгтэй. Бичлэгийг ажлын 10-аас доошгүй хоногийн турш хадгалах ёстой.
- Идэвхжүүлэх хүчин чадал. Камерын үйл ажиллагаа, бичлэгийн функцийг хөдөлгөөн ба дуу гарахаар эсвэл аваарын дохиолол юмуу халдлага илрүүлэх дохиоллоор идэвхжих маягаар тохируулж болно.

Хяналтын камерыг дараах байршилд суурилуулна:

1. Хяналтын камер тухайн бүсэд ажиллаж, бичлэг хийж байгааг олон нийтэд мэдээлэхийн тулд хяналтын камерын тэмдэглэгээг байрлуулах.
2. Нэвтрэх хэсгийн хяналтын хэсэг, шүүхийн танхимд дижитал болон өнгөт хамгаалалтын камер суурилуулах.
3. Цагдан хорих байранд яллагдагчдын үйл хөдлөлийг хянаж байхын тулд хяналтын камер (хөндлөнгийн өртгөөр байрлах) суурилуулах.
4. Шүүхийн эргэн торонд хяналтын камер суурилуулах. Камерын системийг ашиглан сэжигтэй үйл ажиллагаа, осол зөрчлийг илрүүлэх (СЭДЭВ В-8).
5. Олон нийтийн үйлчилгээний хэсэг болон өрөөнүүдэд олон нийтийн үйл хөдлөлийг хянах хяналтын камер суурилуулах (СЭДЭВ В-6).
6. Ачаа тээш ачиж буулгах хэсэгт хяналтын камер суурилуулах (СЭДЭВ В-8).
7. Коридорт хяналтын камер суурилуулах (СЭДЭВ С-5).
8. Шүүхийн өрөө болгонд хяналтын камер суурилуулах (СЭДЭВ В-3).
9. Цахилгаан шат, шатны хонгилд хяналтын камер суурилуулах (СЭДЭВ С-5).
10. Хяналтын станцад нэмэлт хяналтын камер суурилуулах (СЭДЭВ В-5).
11. Өрөөнүүд рүү хүргэх хонгилуудад хяналтын камер суурилуулах (СЭДЭВ В-4).
12. Шуудангийн өрөөнд хяналтын камер суурилуулах.
13. Хүүхдийн асрамжийн төвд (байдаг бол) хяналтын камерыг суурилуулах.
14. Яллагдагчийн зорчих хэсгээр хяналтын камер суурилуулах (СЭДЭВ В-2).



ХАВСРАЛТ

Шүүхийн барилгын аюулгүй байдлын шилдэг практик (АНУ, Охайо муж)

Эдгээр стандарт нь өөрөөр заагаагүй бол Охайо муж дахь бүх шүүхэд хамаарна. Үр нөлөөтэй шударга ёс ба удирдлагыг хангахын тулд эдгээр стандартууд нь хамгийн доод шаардлагыг илэрхийлдэг ба холбооны, муж улсын болон орон нутгийн хуулиуд, дүрэм журам, барилга байгууламжуудад хамаарах хандалт, аюулгүй байдал, харуул хамгаалалтын стандартад нийцүүлэх зорилготой.

(А) Ерөнхий зүйл. Шүүхийн тохиромжтой орчинг бүрдүүлэх олон нийтэд зохих ёсоор үйлчлэхийн тулд цэвэр, гэрэлтүүлэг сайтай, тохирсон халаалттай, агааржуулагчтай шүүхийн байгууламжийг хангаж, хадгалж байх ёстой.

(Б) Байршил. Байгууламжууд нь шүүхийн танхим, мужийн эсвэл хотын барилгад байрлана. Барилга доторх байршил нь шүүхийн бус байгууллагын байршлаас тусдаа байх ёстой. Шүүхийн байгууламжууд нэр төртэй, зохих ёсоор хангагдсан байранд байрлана.

(В) Шүүхийн танхим. Шүүгч бүр тусгай шүүхийн танхимтай байх ёстой.

Хэрэгтэй холбоотой оролцогчид болон бусад хүмүүс зогсоогоор хүлээх эсвэл үүдний өрөөнд хүлээхгүйгээр шүүхийн танхим нь хангалттай суудалтай байх ёстой.

Бүх оролцогчид сонсох ба дуу хоолойгоо сонсгох боломжтой байх ёстой. Хэрэв өрөөнүүдийн акустик хангалтгүй бол үр дүнтэй чанга ярих системтэй байх хэрэгтэй.

Шүүхийн танхим бүр өндөрлөсөн урт сандалтай байх ёстой. Шаардлагатай хууль зүйн лавлах материалын тавиурыг урт сандлын хажууд байрлуулна. Америкийн Нэгдсэн Улс, Охайо муж улсын туг далбаатай байх ёстой.

Гэрчийн сандал урт сандлын хажууд байх ба арай өндөрт байрлах ба ойролцоо байрлалтай байх ёстой.

Шүүхийн танхимд байнга суудаг шүүхийн бүх ажилтнуудад ширээ, сандал байрлуулах ёстой.

Оролцогч талууд болон оролцогч талуудын өмгөөлөгч нарт ширээ сандлыг гаргах шаардлагатай. Ширээ нь бүх оролцогчид харилцан бие бие сонсох боломжтойгоор байрласан байх ёстой ба оролцогч тал өмгөөлөгчтэй хувийн харилцаа холбоо тогтоох боломжийг олгосон байна.

Шүүх хуралдааны танхим бүр шүүхийн танхимд тохирох иргэдийн төлөөлөгчдийн суудлаар тоноглогдсон байх бөгөөд шүүхийн шаардлагыг хангахад хангалттай оролдлого хийнэ. Иргэдийн төлөөлөгчдийн суудал шүүхийн танхимд гэрчдийн зан үйлийг ажиглаж, бүх үйл явдлыг сонсож байхаар байрлах ёстой болно.

Самбар болон бусад шаардлагатай хэрэгслүүд ашиглахад бэлэн байх ёстой. Шаардлагагүй материал болон тоног төхөөрөмжийг шүүх хурал болох шүүхийн танхимд байлгаж болохгүй.



Шүүгч бүр шүүхийн танхимд хувийн шүүхийн хэрэгцээний өрөөтэй байх ёстой. Өрөөнөөс шүүхийн танхим орох зам тусдаа байх ба өрөө тохиромжтой загвараар тоноглогдсон байх ёстой.

(Г) Номын сан. Шүүх тус бүр шүүхэд шаардлагатай гэж үзсэн электрон материал ба шаардлага хангасан хууль зүйн материалаас бүрдэх номын сантай байх ёстой.

(Д) Магистрат. Магистратууд шүүгчдийн адил шүүхийн танхим болон албан тасалгаатай байх ёстой.

(Е) Иргэдийн төлөөлөгч ба гэрч нарын өрөө. Шүүх хуралдааны танхим бүр шүүх хурлын танхимын ойролцоох дуу үл нэвтрэх иргэдийн төлөөлөгчдийн зөвлөлдөөний өрөөтэй байх ёстой. Дуу үл нэвтрэх иргэдийн төлөөлөгчдийн зөвлөлдөөний өрөөнөөс шүүхийн танхимд очих зам нь тусдаа байх ёстой. Иргэдийн төлөөлөгчдөд тусдаа албан бус тав тухтай өрөөнүүдийг гаргасан байх ёстой.

Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан хүлээлгийн өрөө хангалттай байх ёстой ба ерөнхий сонирхлын унших материал, телевиз болон утас байх ёстой.

Мөн Иргэдийн төлөөлөгч нарын өрөөтэй адилхан гэрч нарт зориулсан хүлээлгийн өрөө байх ёстой.

(Ж) Зөвлөгөө өгөх өрөө. Өмгөөлөгчдөд ашиглагдахаар зориулагдсан өрөө байх шаардлагатай болно.

(З) Зөрчлийн хэлтэс болон төлбөрийн цонх (pay-in windows). Зөрчлийн хэлтэс болон төлбөрийн цонх нь нийтийн машины зогсоолын ойролцоо байрлуулах байх ёстой.

(И) Шүүхийн ажилтнууд болон шүүхийн ажилтнуудад зориулсан байгууламжууд. Шүүхийн бүртгэлийг бэлтгэх, хадгалахад хангалттай орон зай болон тоног төхөөрөмж шүүхийн ажилтнуудад шаардлагатай. Бүтээмж, аюулгүй байдал, нууцлалыг хангахын тулд орон зай болон тоног төхөөрөмжийг ашиглах хэрэгтэй.

Нийтийн ариун цэврийн өрөө шүүгч болон шүүхийн ажилчдын ариун цэврийн өрөөнөөс тусдаа байх шаардлагатай.

(К) Нийтийн тав тухтай орчин. Цэвэр, орчин үеийн ариун цэврийн өрөө нь шүүхийн нийтийн хүрээний ойролцоо байх ёстой ба олон нийтийн телефон утас нь тааваараа байх нөхцлийн бүрдүүлэн хангах ёстой.



Шүүхийн байгууламжийн аюулгүй байдлыг шалгах хуудас (АНУ, Аризона муж)

Танилцуулга

Аризонагийн Дээд шүүх 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Шүүхийн Аюулгүй Байдлын Стандартыг баталсан.⁶ Шүүхийн аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах байнгын үйл явцаар дамжуулан явуулдаг. Дэлгэрэнгүй арга барилын хувьд шүүхийн аюулгүй байдлыг хянах нь бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөлтийг багтаасан байх ба яаралтай бэлэн байдал зэргийг хамарна.

Шүүхийн аюулгүй байдлын 1-р стандарт нь орон нутгийн болон мужийн Шүүхийн Аюулгүй Байдал, Онцгой Байдлын Бэлтгэлийн Хороо ("ШАБОББХ") байгуулахыг шаарддаг. Шүүхийн төлөөлөгчид, хууль сахиулах байгууллага, анхны тусламж, бусад оролцогч талуудаас бүрдэх ШАБОББХ нь шүүхийн аюулгүй байдал, онцгой байдлын бэлэн байдлын бүх талуудад бодлого чиглэл, төлөвлөлтийн зөвлөмж өгөх үүрэгтэй.

Шүүхийн аюулгүй байдлын стандартын дагуу аюулгүй байдлын бодлого, журмыг боловсруулах, шинэчлэх, аюулгүй байдлын будилааны хариу үйлдлийн системийг бий болгох зэрэг аюулгүй байдлыг сайжруулах шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд шүүх болон ШАБОББХ нь аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийх ёстой.⁷ Шүүхийн аюулгүй байдал нь харилцан хамаарал бүхий гурван хэсэгтэй: (1) шүүхийн үйл ажиллагаа, (2) байгууламж, тоног төхөөрөмж, (3) сургалт, харилцаа холбоо. Аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагааны үр дүнг байнгын сургалт болон аудитаар үнэлэх хэрэгтэй. Шүүхийн аюулгүй байдлыг дээд зэргээр нэмэгдүүлэхийн тулд энэхүү үргэлжилсэн үйл явцын ачаар ШАБОББХ болон шүүхийн манлайлал үнэтэй санал хүсэлт, зөвлөмж авч чадна.

Энэхүү шалгах хуудас нь шүүгчид, ажилтнууд болон шүүхийн байгууламж дахь олон нийтийн аюулгүй байдлыг хангахын тулд шүүх бүр юу хийж байгаа мөн юу хийхгүй байгаа талаар нарийвчлан тайлбарлах суурь үнэлгээ хийхэд хувийн шүүх болон ШАБОББХ-д туслах явдал юм. Энэхүү шалгах хуудасны тусламжтай хэрэгцээний тайланг гаргаж, Шүүхийн аюулгүй байдлын стандартад хүрэхийн тулд бүх шүүхийн хэрэгцээг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад ШАБОББХ-д туслах зорилгоор бусад байгууламжуудын шалгах жагсаалттай уялдаж байх ёстой.

Шалгах хуудсыг бөглөх заавар:

Шүүхийн аюулгүй байдлын үнэлгээг аюулгүй байдлын хэрэгцээ болон шүүхтэй холбоотой асуудлуудын талаарх сайн мэдлэгтэй хувь хүн удирдана. Хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд доорх алхмуудыг дагана уу:⁸

⁶ Supreme Court Administrative Order 2017-015.

<http://www.azcourts.gov/Portals/74/CSSC/AO/AO%202017-15.pdf>

⁷ Security Standard 3, Appendix to Supreme Court Administrative Order 2017-015.


<http://www.azcourts.gov/Portals/74/CSSC/AO/AO%202017-15.pdf>

⁸ See Nathan W. Hall, et. al. *Steps to Best Practices for Court Building Security*, September 2016, National Center for State Courts.



1. Шалгах хуудсыг хэвлэн агуулгатай нь танилцана уу.
2. Шалгах хуудас бөглөхдөө шүүхийн голлох хүмүүс болон томилогдсон хүмүүсийг оролцохыг зөвлөдөг. Энэ нь нээлттэй хэлэлцүүлэг, ерөнхий нөхцөл байдлыг илүү сайн ойлгох боломжийг олгоно.
3. Шалгах хуудсыг бөглөхдөө эргэлзэж байгаа зүйл дээрээ "мэдэхгүй" гэж тэмдэглэнэ.
4. Хэрэв боломжтой бол, шалгах хуудсаа бөглөн явахдаа онцлон дурдсан газруудын зургийг авч болно. Зураг мянган үг хэлдэг гэдгийг санаарай.
5. Та бүх мэдээллээ цуглуулж, шалгах хуудас бөглөж дууссаны дараа дахин нягтлан үзэж шаардлагатай тохиолдолд нэмэлт арга хэмжээг авна.
6. Үр дүнгийн тайланг бөглөнө (загварыг тусад нь өгсөн), энэ нь таны зөвлөгөөг амьдруулан дэмжлэг үзүүлэх зургийг оруулах хэсэг.
7. Үр дүнгийн тайлангийн загвар нь шалгах хуудастай таарч байх ёстой. Гэхдээ олсон үр дүнгийн тайлан нь хяналтын хуудасны хэсэг бүрийн дэлгэрэнгүй хэсэг байдаг.
8. Тайландаа та зөвлөмжөө нарийвчлан тусгах хэрэгтэй, үүнд тайлангийн хураангуйг оруулна. Тайлангийн хураангуй хэсэгт өөрийн зөвлөмжүүдийг жагсааснаар тайлангийн бие хэсгээс олж уншихад амар байх болно.
9. Шалгах хуудасны эхэнд холбоо барих мэдээллийн хэсгийг бөглөнө. Үнэлгээнд оролцсон бүх талуудыг жагсааж бичнэ. Эцэст нь үр дүнг бүх холбогдох талуудад хүргүүлнэ.

Тайлбар: Үнэлгээ, зөв бөглөсөн бол, нууц мэдээлэл агуулах бөгөөд Арizonaгийн Дээд шүүхийн 123 дугаар дүрмийн дагуу олон нийтэд нээлттэй бус нууц бичиг баримт гэж харьцах ёстой.





ШАЛГАХ ХУУДАС

#	Хэсэг 1. Шүүхийн аюулгүй байдлын протокол	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт галт зэвсэг оруулах бодлого байдаг уу? Дараах бодлогыг боловсруулсан: Гэрч /үзэгчид/ хувийн асуудлуудын тухай хууль сахиулах <input type="checkbox"/> Албан ёсны бизнесийн тухай хууль сахиулах <input type="checkbox"/> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага <input type="checkbox"/> Шүүгч /ажилтнууд/ бусад аюулгүй байдлын ажилтнууд <input type="checkbox"/> Өмгөөлөгчид /бусад/ <input type="checkbox"/>			
2	Шүүхийн танхимд дүрэмт хувцастай аюулгүй байдлын ажилтнууд байдаг уу?			
3	Зэвсэглэсэн аюулгүй байдлын ажилтнууд байдаг уу?			
4	Шүүхийн танхимаас бусад газарт хоригдлууд хязгаарлалтад байдаг уу?			
5	Шүүхийн танхим руу ирж очих хоригдлуудын хөдөлгөөнийг хариуцсан төлөөлөгч байдаг уу? Төлөөлөгч _____			
6	Өндөр эрсдэлтэй туршилт/үйл явдлыг боловсруулах протокол байдаг уу?			
7	Шүүхийн танхимаас яаралтай нүүлгэн шилжүүлэх журам байдаг уу? Дараах субъектүүдэд хамаарах бодлогыг боловсруулсан: Шүүгч <input type="checkbox"/> Шүүхийн ажилтнууд <input type="checkbox"/> Шүүхийн төлөөлөгчид <input type="checkbox"/> Хоригдлууд <input type="checkbox"/>			
8	Ашиглаагүй үед шүүхийн танхимыг түгжих зохицуулалт байдаг уу?			
9	Ажлын цагаар шүүх хуралдааны өрөө рүү орж гарахыг хянадаг уу?			
10	Аюулгүй байдал/хамгаалалтын асуудлуудыг хянах осол мэдээлэх систем бий юу?			

#	Хэсэг 2. Шүүхийн аюулгүй байдлын журам	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Шүүхийн танхимын хамгаалалтын ажилтан бий юу?			
2	Хамгаалалтын ажилчид зэвсэглэсэн үү?			
3	Шүүхийн танхимыг өдөр болгон байнга шалгаж байх журам байдаг уу?			
4	Зэвсэг шалгах төхөөрөмжүүд нийтийн хаалган дээр байнга ашиглагддаг уу? Гар төхөөрөмж <input type="checkbox"/>			



	Металл илрүүлэгч хаалга <input type="checkbox"/> Рентген машин <input type="checkbox"/>			
5	Сандал нь сум нэвтрүүлдэггүй бэхэлгээтэй юү? Ямар: _____			
6	Аюулгүй байдлын дохиолол, яаралтай гэрэлтүүлэг, мөн илрүүлэх тоног төхөөрөмжийг байнга шалгалт хийдэг үү?			
7	Өмгөөлөгч-үйлчлүүлэгчдийн хурлын өрөө бий юү?			
8	Гэрч нарт хүлээлгийн өрөө байгаа юү?			
9	Шүүхийн төлөөлөгчдийн хэлэлцүүлгийн өрөө шүүх хуралдааны танхим руу шууд орж болох хяналттай юү?			
10	Шүүхийн төлөөлөгчдийн хэлэлцүүлгийн өрөөг төлөөлөгчид орж ирэхээс өмнө танхимд сайтар үзлэг хийдэг үү?			
11	Шүүхийн төлөөлөгчдийн хэлэлцүүлгийн өрөөг эзгүйд түгждэг үү?			
12	Галт зэвсэг зэрэг хориотой зүйлсийн талаар тэмдэг тавьдаг уу?			
14	Эрэн сурвалжилж байгаа хүмүүсийн талаар мэдээлэл тавьдаг уу?			

#	Хэсэг 3. Онцгой байдлын төлөвлөлт	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Байршил нь онцгой байдлын менежментийн төлөвлөгөөтэй юү?			
2	Төлөвлөгөөг шинэчилж, үе үе хянан үздэг үү?			
3	Гал, яаралтай тусламжийн нүүлгэн шилжүүлгэнд буцаан оруулах үйл явц төлөвлөсөн үү?			
4	Ажилчдад төлөвлөсөн хэсгийг тодорхойлж мэдээлсэн үү?			
5	Онцгой байдлын зохицуулагчдыг томилсон уу?			
6	Төлөвлөгөөнд бөмбөгдөлтийн аюул заналхийллийн элемент болон галт зэвсгийн хариу үйлдэл орсон уу?			
7	Онцгой байдлын үед ажилчид өөрсдийнхөө үүргийн талаар мэдэж байгаа юү?			
8	Сургалтад асуулга явуулдаг уу? Сүүлийн сургалтын он сар өдөр _____			
9	Байршилд СООР бий юү?			
10	Яаралтай тусламжийн гинжин командыг тодорхойлсон уу?			

#	Хэсэг 4. Дохиолол ба камер	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Барилга нь халдлагын дохиололтой юү?			
2	Бүх дохиолол онцгой байдлын тэжээлийн эх үүсвэртэй юү?			
3	Аюулгүй байдлын дохиоллын системийг байнга шалгадаг уу? Хэр ойрхон?			



	Систем хаана зогсдог вэ? Хэн хариу өгдөг вэ?			
4	Сэрэмжлүүлэх мэдэгдлийн жагсаалт файлд байгаа юу? Шинэчлэгдсэн үү? Хэн жагсаалтыг шинэчлэх эрхтэй вэ?			
5	Ажиллахаа больсон ажилчдын кодыг системээс хассан уу?			
6	Аюулгүй байдлыг шалгах, системийн засвар үйлчилгээний бүртгэл хөтөлдөг үү? Ашиглах боломжтой юу?			
7	Системд засвар үйлчилгээ хийх томилогдсон байгууллага бий юу?			
8	Байршилд ажиглалтын төхөөрөмж суурилуулсан уу?			
9	Хяналтын систем орох, гарах цэгийг хянадаг уу?			
10	Хяналтын систем зогсоолын хэсгийг хянадаг уу?			
11	Хяналтын систем лобби ба хүлээлгийн хэсгийг хянадаг уу?			
12	Хяналтын системийг удирдан хянадаг хүн байдаг уу? Тандалтын систем? Хянагч:			
13	Хяналтын системийн хүрээнд ажиглагдсан сул талууд юу вэ? Тодорхойлно уу:			
14	Видео бичлэгийг дэлгэх бодлого, журам байдаг уу?			
15	Байгууламж нь үйл ажиллагаа шалгах тоног төхөөрөмж, үүнийг удирдсан хүн бий юу?			
16	Шүүхийн танхимд аваарын дохиолол байгаа юу?			
17	Үйлчилгээний хэсгүүдэд аваарын дохиолол байгаа юу?			
18	Шүүхийн хаалга/аюулгүй байдлын үзлэгийн хэсэгт Аваарын дохиолол байгаа юу?			
19	Аваарын дохиоллыг байнга туршиж шалгадаг уу? Хэрэв тийм бол хэр ойрхон?:			
20	Ажилчид аваарын дохиоллын хэрэглээний талаарх зохих ёсны сургалтанд хамрагдсан уу?			
21	Аваарын дохиоллын хариу байршлыг тодорхойлсон бөгөөд зохистой хариу арга хэмжээ авах талаар сургалт явуулсан уу?			



#	Хэсэг 5. Ажилчдын сургалт	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Ажилчид тогтмол аюулгүй байдал, хамгаалалтын дадлага, сургалт хийдэг үү?			
2	Ажилчдад дотоод аюулгүй байдлын арга хэмжээний талаарх мэдээлэл олгосон үү?			
3	Аюулгүй байдал, хамгаалалтын сургалт хариуцдаг хувь хүн бий юу? Түүний нэр: _____			
4	Барилгад давхар, хэсгийн онцгой байдлын зохицуулагч байгаа юу?			
5	Ажиллахаа больсон ажилчдын кодыг системээс хассан уу?			

#	Хэсэг 6. Нийтийн хүлээлгийн хэсэг	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Нийтийн хүлээлгийн хэсэг байдаг уу?			
2	Нийтийн хүлээлгийн хэсгийг ажилчид хянадаг уу?			
3	Олон нийт ажилтнуудын хэсэгт чөлөөтэй нэвтрэх эрхтэй юу?			
4	Ажилчдыг олон нийтээс биечлэн хамгаалах зүйлс байдаг уу? (жишээ нь: хуваалт, хатуу/пластик/цуурдаггүй шил)			
5	Ажилчид нийтийн хэсэгт туслалцаа дуудахад хялбар уу? Тайлбарлана уу _____			
6	Хогийн саванд хаясан хог хаягдал нь контрабандыг нуух боломжтой уу?			

#	Хэсэг 7. Ажилчдын хэсэгт олон нийт орох	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Ажилчдын хэсгийн зочдын хөдөлгөөнийг хянах арга хэмжээ байдаг уу?			
2	Ажилчдын хэсэгт орохоос нь өмнө шалгуулж, нэвтрэх эрхтэй эсэхийг шалгадаг уу?			
3	Ажилчдын хэсэгт зочлогсод ямар нэгэн байдлаар тодорхойлдог уу?			
4	Зочлогсод /олон нийт/-ыг ажилтнууд дагалдаж явдаг уу?			
5	Зочдыг угтах, тусламж шаардлагатай эсэхийг асуух хэвшлийг ажилтнуудад сургасан уу?			
6	Бүх хана тааз хүрсэн байдаг уу?			
7	Шүүхэд авагддаг буюу зөөгддөг тааз байдаг уу? Байршил: _____			
8	Доод хонгил болон нийтийн бус гаднах хаалгануудад аваарын дохиолол байдаг уу?			
9	Хонгилын хаалгуудыг ажиллаагүй үед бэхэлж, түгждэг үү?			
10	Олон нийтийн хэсгээр байнга хяналт хийдэг үү?			
11	Шүүхийн танхимын дэргэд хүлээлгийн өрөөнд байнга			



	хяналт хийдэг үү?			
12	Нийтийн ариун цэврийн өрөөнд байнга хяналт хийдэг үү?			
13	Ариун цэврийн өрөө нь шүүхийн танхимын дэргэд байрладаг уу?			

#	Хэсэг 8. Ажилчдын хэсэг	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Ажилчдын хэсэгт орох хэсгийг хянадаг уу?			
2	Олон нийт хардаггүй ажилчдын өрөө байдаг уу?			
3	Ажилчдын хэсэгт аюулгүй байдлын шалгалт хийдэг үү?			
4	Гал унтраагчийг тэмдэглэн, гар хялбар хүрэх газар байрлуулсан уу?			
5	Ажилтнууд зурагтай таних тэмдэг бүхий карт зүүдэг үү?			
6	Ажилчид таних тэмдэг бүхий картаа шинэчлэх шаардлагатай байдаг уу?			
7	Таних тэмдэг бүхий картгүй зочдыг, "танд юугаар туслах уу" гэж угтдаг уу?			
8	Ажилчдын амралтын өрөө/хурлын танхим олон нийтийн хараанд байдаг уу?			
9	Аюулгүй байдал болон хамгаалалтын анхааруулгыг байрлуулсан уу?			
10	BOLO мэдэгдлүүдийг хэрэгжүүлдэг үү?			
11	Ажилчдын хэсэгт файл эсвэл бүртгэл үлдээсэн үү?			
12	Ажилчдыг барилгад нэвтрэхийн тулд аюулгүй байдлын дамжлагад хамрагдах шаардлагатай юу?			

#	Хэсэг 9. Бусад аюулгүй байдлын систем	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Байгууламж нь электрон карт эсвэл тэмдгийн хандалтын системтэй юу?			
2	Цахилгаангүй болсон үед цахилгааны хаалга нээлттэй болдог уу?			
3	Нэмэлт хаалганы картуудыг цоожтой/хязгаарлагдмал газар хадгалдаг уу?			
4	Ажлаас гарсан, өөрчлөгдсөн гэх мэт ажилчдад байнгын аудит хийдэг үү? Хамгийн сүүлийн аудитын өдөр: _____			
5	Ажлаас гарахад карт, тэмдгийг буцаан авдаг уу?			
6	Шүүх танхимын цонхыг гаднаас харагдахгүй байх арга хэмжээ авсан уу?			
7	Нийтийн харилцааны систем хангалттай юу? Хангалтгүй байдал: _____			
8	Шүүхэд нийтийн харилцааны системийн нөөц байгаа уу? Хэрэв тийм бол тодорхойлно уу:			



9	Шүүхийн ажилтнууд утасны системийг харилцааны систем болгон ашиглаж болох уу?			
10	Нийтийн харилцааны системийг ашиглах томилогдсон хүн байгаа юу?			
11	Шүүхийн аюулгүй байдлын ажилтнууд аюулгүй байдлын зорилгоор тусгай харилцааны системийг ашигладаг уу?			
12	Шүүхийн хамгаалалтын ажилтнууд радио систем ашигладаг үү?			
13	Хэрэв шүүхийн аюулгүй байдлын ажилтнууд радио системийг ашигладаг бол яаралтай тусламжийн зориулалтаар радио нь бусад гадны байгууллагуудтай холбогдож болох уу?			

#	Хэсэг 10. Түлхүүрийн хяналт	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Түлхүүрүүдийг хямгадаагүй эсвэл түлхүүрийн картыг идэвхгүй болгосон бол цоожнуудыг сольдог уу?			
2	Түлхүүр хянах менежер байгаа юу?			
3	Илүү түлхүүрүүд нь цоожтой хайрцаг/газар хадгалагддаг уу?			
4	Түлхүүр хянах бүртгэл хөтөлдөг үү?			
5	Гарах ярилцлагын үйл явцад түлхүүр буцаан авдаг үү?			
6	Барилгын түлхүүрийг зөвхөн тодорхой хүмүүст олгодог уу?			
7	Мастер түлхүүрүүдийг хатуу хяналттай газар хадгалан, хатуу хяналтын дагуу олгодог уу?			
8	Шүүгч болон шүүхийн ажилтнууд барилгад тусгай хаалгаар ордог уу?			

#	Хэсэг 11. Бусад	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Шүүх танхим дахь хууль бус юм уу аюултай зүйлсийг тогтмол шалгадаг уу?			
2	Хамгаалалттай танхим/өргөөнд орж гарч буй бүх зочид, борлуулагчдыг хянадаг уу?			
3	Ашиглаагүй үед танхимыг түгждэг үү?			
4	Шүүгчийг машины зогсоол, танхим, шүүхийн өрөө хооронд явахад нь тогтмол дагалдан явдаг уу?			
5	Гаднаас шүүхэд авчирсан цагдан хорих хүмүүсийг нийтийн орох хаалгаар оруулдаг уу?			
6	Баривчлагдсан хүмүүсийг шүүхийн хүлээн авах хэсэгт авч ирэхдээ аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авдаг уу? Хэрэв тийм бол: Цахилгаан шат <input type="checkbox"/> Шат <input type="checkbox"/>			



	Туннел <input type="checkbox"/> Гүүр <input type="checkbox"/> Тээврийн хэрэгсэл <input type="checkbox"/> Хөл <input type="checkbox"/>			
7	Нийтийн хаалганаас тусдаа баривчлагдсан хүмүүсийн орох хаалга нь олон нийтийн хараанаас далд газар байдаг уу?			
8	Шүүгч болон шүүхийн ажилтнууд цагдан хоригдсон хүмүүсийн ашигладаг хэсгээр бас явдаг уу?			
9	Түр саатуулах байр/өрөө байдаг үү?			
10	Түр саатуулах байр/өрөөнөөс аюулгүй, хязгаарлагдмал хэсэгт шууд орох боломжтой юу?			
11	Дор хаяж нэг саатуулах байр/өрөө нь шүүхийн үйл ажиллагааг харуулсан аудио болон дүрс бичлэгийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон уу?			
12	Хоригдлуудыг түр саатуулах байр/өрөөнд байлгадаг уу?			
13	Нэмэлт хязгаарлалтын ашиглах төхөөрөмж байгаа юу?			
14	Түр саатуулах байр/өрөөнд хууль бус зүйлсийн шалгалт байнга хийдэг үү?			
15	Цагдан хоригдож байгаа хүмүүсийг онцгой байдлын үед нүүлгэн шилжүүлэх журам байдаг уу?			
16	Аюулгүй байдал, тээврийн ажилтнуудыг онцгой байдлын үед цагдан хоригдож байгаа хүмүүсийг хэрхэн нүүлгэн шилжүүлэх талаар сургалтад хамруулдаг уу?			
17	Цагдан хоригдож байгаа хүмүүст онцгой байдлын үед эмнэлгийн тусламж үзүүлэх журам байгаа юу?			

#	Хэсэг 12. Босоо хөдөлгөөн ба шатны хонгил	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Ажилчдад зориулсан тусгай цахилгаан шат байгаа юу?			
2	Шүүгчид зориулсан тусгай цахилгаан шат байгаа юу?			
3	Ажилчид/шүүгчийн цахилгаан шатыг програмчилж болох уу?			
4	Ажилчид/шүүгчийн цахилгаан шатыг хянаж болох уу?			
5	Ажилчид/шүүгчийн цахилгаан шатанд яаралтай холбооны хэрэгсэл байдаг уу?			
6	Олон нийт ашиглах зориулалттай цахилгаан шат байдаг уу?			
7	Олон нийтийн цахилгаан шатыг програмчилж болох уу?			
8	Олон нийтийн цахилгаан шатыг хянаж болох уу?			
9	Зөвхөн цагдан хоригдож байгаа хүмүүсд зориулсан цахилгаан шат байдаг уу?			
10	Цагдан хоригдсон хүмүүсийн цахилгаан шатыг гарч буй давхрын дагуу програмчилж болох уу?			



11	Цагдан хоригдсон хүмүүсийн цахилгаан шат түлхүүр хяналттай юу?			
12	Цагдан хоригдсон хүмүүсийн цахилгаан шатыг баар, сараалжаар тоногдсон уу?			
13	Цагдан хоригдсон хүмүүсийн цахилгаан шатыг аюулгүй байдлын төхөөрөмжүүдээр тоногдсон уу? Хэрэв тийм бол: Дохиолол <input type="checkbox"/> Утас <input type="checkbox"/> Камер <input type="checkbox"/> Бусад <input type="checkbox"/> Тайлбарлана уу			
14	Олон нийтийн бус шатны хонгил түгшүүрийн дохиололтой юу?			
15	"Аюулгүй байдлын гарц" нь "ослын үед нээгддэг систем" болон аваарын дохиололтой юу?			

#	Хэсэг 13. Галын дохиолол болон зогсоох систем	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Байшинд галын дохиоллын систем байдаг уу?			
2	Байшинд ус шүршигч систем байдаг уу?			
3	Ус шүршигч системийг байнга туршиж үздэг үү?			
4	Утаа мэдрэгч суурилуулсан уу?			
5	Утаа мэдрэгчийг тогтмол шалгадаг уу?			
6	Галын дохиоллын хяналтын самбар байдаг уу?			
7	Галын дохиоллын систем автомат системд холбогдсон уу?			
8	Галын хонгилд онцгой байдлын гэрэлтүүлэг байдаг уу?			
9	Галын хонгил нь хог хаягдалгүй юу?			
10	Цагдан хоригдсон хүмүүсийн цахилгаан шатыг гарч буй давхрын дагуу програмчилж болох уу?			
11	Галын гарц нь аваарын дохиололтой юу?			
12	Шүүх дотоодын галын кодыг мөрддөг үү?			

#	Хэсэг 14. Хэрэгсэл ба яаралтай тусламж	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Эрчим хүчний эх үүсвэр найдвартай юу?			
2	Онцгой байдлын үед туслах нэмэлт тэжээлийн эх үүсвэр байдаг уу?			
3	Онцгой байдлын гэрэлтүүлэг байдаг уу?			

#	Хэсэг 15. Хаалга, цонх, нээлттэй хэсэг	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Бүх гадна хаалгууд цилиндр цоож, чанартай өлгөдөг цоож, оньсон цоожтой юу?			
2	Бүх гадна хаалгууд халдлагын дохиоллоор тоноглогдсон уу?			



3	Бүх нугасны голууд нь дотор талдаа байрлаж, хялбархан авахаас сэргийлж, гагнагдсан уу?			
4	Гадна хаалгууд өөрөө хаагдан түгжигдэхээр тоноглогдсон уу?			
5	Түгжигдсэн хаалгын түгжээг гаргаж болох уу?			
6	Гадна цоож түгжээтэй байдаг уу?			
7	Бүх ашиглагдаагүй хаалгыг байнга түгждэг үү?			
8	Агааржуулалт хийхэд бүх цонх хамгаалалттай байдаг уу?			
9	Гадна шилэн сайтар наалттай, дулаалсан байдаг уу?			
10	Нээлттэй цонх болгонд тохиромжтой цоож байдаг уу?			
11	Шилэн завсарлагатай цонхнууд халдлагын дохиололтой юу?			
12	Гаднаас харагдуулахгүй байх үүднээс цонхны наалттай юу?			
13	Хялбархан салгахаас сэргийлэхийн тулд цонхонд бэхэлгээ хийсэн үү?			
14	Хялбар салгахаас сэргийлсэн агааржуулалтын хучлага байдаг уу?			

#	Хэсэг 16. IT аюулгүй байдал, бүртгэл, хадгалалт	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Ажиллахаа больсон ажилчдыг сүлжээ, и-мэйлд нэвтрэх эрхийг хасдаг уу?			
2	Ажиллахаа больсон ажилчдыг утас ашиглах эрхийг хасдаг уу?			
3	Ажиллахаа больсон ажилчдын картыг хураадаг уу?			
4	Ажиллахаа больсон ажилчдад өгсөн эд хөрөнгө (гар утас, зөөврийн компьютер, таблет)-ийг буцаан авдаг уу?			
5	Баримт бичгийг хадгалдаг аюулгүй газар байдаг уу?			
6	Ажлын цагийн дараа бичиг баримтыг хамгаалдаг уу?			
7	Ажлын цагаар бичиг баримтыг хамгаалдаг уу?			
8	Баримт бичгийг хадгалах хэсэг гал түймэртэй тэмцэх төхөөрөмжөөр тоноглогдсон уу?			
9	Баримт бичгийг хадгалах хэсгийг хянадаг уу?			
10	Зоорь, үйлчилгээний өрөө, халуун усны өрөө, харанхуй өрөө, манаачийн хэсэг ашиглагдаагүй үед цоожтой байдаг уу?			
11	Харанхуй өрөөнд зөвшөөрөлгүй нэвтрэхээс хамгаалагдсан уу?			
12	Шүүхэд аюултай бодис хадгалдаг уу? Хэрэв тийм бол: Зэвсэг <input type="checkbox"/> Зэр зэвсэг <input type="checkbox"/> Нулимс асгаруулагч хий <input type="checkbox"/>			



	Бусад <input type="checkbox"/> Тайлбарлана уу			
--	---	--	--	--

#	Хэсэг 17. Сейф / касс	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Сейф/кассыг ашигладаг уу Тайлбарлана уу:			
2	Сейф/касс гал үнэлгээтэй юу?			
3	Сейф/касс дохиолол, хяналттай юу?			
4	Сейф/касс нийтийн хүрч болохуйц газарт байдаг уу?			
5	Хадгаламжийн баталгааг хангах протоколууд бий юу?			

#	Хэсэг 18. Дээврийн хэсэгт нэвтрэх	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Дотроосоо дээвэрт нэвтрэх боломжтой юу?			
2	Барилгын гаднах нээлттэй хэсэг хяналттай байдаг уу?			
3	Дээврийн нээлттэй хэсэг халдлагын дохиололтой юу?			
4	Бусад хэсгээр дээвэр рүү нэвтрэх боломжтой юу? (гал аврах, бусад барилга байгууламжаас, гэх мэт)			

#	Хэсэг 19. Барилгын периметр	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Байгууламжийн периметр нь хашаа, эсвэл бусад төрлийн биет саадаар тодорхойлсон уу? Саад болон түүний нөхцөл байдлыг товч тайлбарлана уу:			
2	Саадыг тээврийн хэрэгсэл, явган хүний хөдөлгөөнийг хязгаарладаг уу?			
3	Хашаа нь бат бөх, сайн нөхцөлд байгаа юу?			
4	Хашааг сайтар түгжин хамгаалсан уу?			
5	Хашааны нугас хамгаалагдсан уу?			

#	Хэсэг 20. Зошсоол	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Машины зогсоолыг хянадаг видео эсвэл өөр хяналтын систем байдаг уу?			
2	Ажилчдад зориулсан машины зогсоолын зай байгаа юу?			
3	Ажилчдыг зогсоолын талбайд хяналттай оруулдаг уу? Хэрэв тийм бол ямар төрлийн хяналтын систем ашигладаг талаар тайлбарлана уу:			
4	Зарим албан тушаалтнуудад/хэлтэсд зориулсан зогсоол байгаа юу?			
5	Тусгай зогсоол нэр биш дугаараар тэмдэглэгдсэн байдаг уу?			



6	Шүүгчид зориулсан зогсоол байдаг уу?			
7	Шүүхийн төлөөлөгчид болон гэрчид зориулсан зогсоол байдаг уу?			
8	Шүүгчид зогсоолоос нийтийн бус цахилгаан шат, тусгай коридорт хүргэх шууд хаалга байгаа юу?			
9	Тусгай зогсоолыг гал/цагдаа/түргэн тусламж хязгаарладаг уу?			
10	Авто зогсоол хангалттай гэрэлтүүлэгтэй юу?			
11	Ажилчдад зориулсан машины зогсоол харьцангуй ойр байдаг уу?			
12	Тусгай зогсоол гэсэн тэмдэглэгээ байгаа юу?			

#	Хэсэг 21. Барилгын гадна гэрэлтүүлэг	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Барилгын гаднах хэсэг гэрэлтүүлэгтэй юу? Тайлбарлана уу: Бүрэн гэрэлтүүлэгтэй <input type="checkbox"/> Зарим хэсэг гэрэлтүүлэгтэй <input type="checkbox"/> Гэрэлтүүлэггүй <input type="checkbox"/>			
2	Бүх гаднах гэрэл шөнө байнга асдаг уу?			
3	Утаснуудыг нь тогтмол шалгадаг уу?			
4	Гэрэлтүүлгийг автоматаар хянадаг уу?			
5	Хяналтын унтраалгыг зөвхөн зөвшөөрөлтэй хүмүүст хүрч чадах газар байрлуулдаг уу?			
6	Барилгын хана, хогийн савны ойролцоо хууль бусаар нэвтрэн тэсрэх төхөөрөмжийг байрлуулахаас сэргийлэх зориулалтаар барилгын эргэн тойрон хангалттай гэрэлтүүлэгтэй юу?			
7	Гадна эсвэл периметр дахь гэрлүүд туслах тэжээлийн эх үүсвэртэй юу?			
8	Нийтийн эзэмшлийн газрууд, явган хүний зам, зогсоол зэрэг газрууд хүн эсвэл тээврийн хэрэгслийн дайралтаас зайлсхийх хангалттай гэрэлтүүлэгтэй юу?			
9	Нүдэнд харагдахгүй, далд харанхуй газар байдаг уу?			



#	Хэсэг 22. Гаднах гэрэлтүүлэг	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Ландшафтын онцлогт хүмүүс нуугдахад тохирохуйц газар байдаг уу?			
2	Зэвсэг болгон ашиглаж болох сул эд зүйлс (тоосго, чулуу, саваа) байна уу?			
3	Гол хаалга гол замруу харсан уу?			
4	Ландшафт гэрэлтүүлгийг хаадаг уу?			
5	Гэрэлтүүлгийг сайжруулах боломжтой юу?			
6	Талбай нь хавтгай, бүх зүйл сайн харагддаг уу?			
7	Тухайн газарт хүн нуугдаж болохуйц ямар нэгэн хэсэг байгаа юу?			
8	Бут, модыг байнга тарьдаг уу?			

#	Хэсэг 23. Хяналтын тэмдэг	Тийм	Үгүй	Боломжгүй
1	Ажилчдын орох, гарах гарцыг заах тэмдэг байрлуулсан уу?			
2	Үйлчлүүлэгчдийн орох, гарах гарцыг заах тэмдэг байрлуулсан уу?			
3	Хүргэлтийн хэсгийг заах тэмдэг байрлуулсан уу?			
4	Ландшафт гэрэлтүүлгийг хаадаг уу?			
5	Үйлчлүүлэгчдийн зогсоолыг заах тэмдэг байрлуулсан уу?			
6	Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг байрлуулсан уу?			
7	Галын гарцыг тэмдэглэсэн, зориулалтын гэрэлтүүлэгтэй юу?			
8	Гал унтраагчийн тэмдэг байрлуулсан уу?			
9	"Онцгой байдлын" гарцыг харуулсан тэмдэг байрлуулсан уу?			
10	Ус шүршигчийн системийг хянах самбар байрлуулсан уу?			
11	Хориглосон эд зүйлсийн тухай мэдээлэл байрлуулсан уу?			
12	Эрэн сурвалжилж байгаа хүний тухай мэдээлэл байрлуулсан уу?			